

Монгол Улс, ХБНГУ-ын хөгжлийн бодлого ба хоёр талын албан ёсны техникийн хамтын ажиллагааны тухай

Нэг. ХБНГУ-ын хөгжлийн бодлого ба Монгол-Германы хөгжлийн хамтын ажиллагаа

ХБНГУ-ын хөгжлийн бодлогын түүхнээ Германы болон дэлхийн үндэс төр, эдийн засгийн томоохон өөрчлөлтүүд тухайлбал, олон улсын харилцааны хоёр туйлт систем дуусгавар болсон, 2001 оны 9-р сарын 11-ний террорист халдлага зэрэг нь ХБНГУ-ын хөгжлийн бодлогын стратегид үндсэн өөрчлөлтийг оруулсаар иржээ.

1952 онд ХБНГУ анх удаа гуравдагч орнуудын эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий "НҮБ-ын өргөтгөсөн тусламжийн хөтөлбөр"-т санхүүгийн оролцоог үзүүлэх хэлбэрээр хөгжлийн тусламжийг үзүүлэх болсноос¹ хойш 1961 онд Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (ХЭЗХАХЯ) нь хөгжлийн хамтын ажиллагааг хариуцсан бие даасан яам болж байгуулагдсан байна.² Энэ нь Холбооны Засгийн газрын зүгээс хөгжлийн бодлогод багагүй ач холбогдол өгөх болсныг нотолж байна.

1960-аад оны үед ХБНГУ-ын хөгжлийн бодлогод Өрнө-Дорнын сөргөлдөөн гүнзгий нөлөөлж байсан бол 1970-аад оны эхэн үед ХБНГУ-ын Канцлер Вилли Брандтын Дорнын бодлогын үр шимээр ХБНГУ-ын зүгээс БНАГУ болон Зүүн Европын орнуудтай харилцаагаа хэвийн болгох анхны алхмууд болж Дорнын гэрээнүүд байгуулагдсанаар ХБНГУ-ын хөгжлийн бодлогын үндсэн чиглэл өөрчлөгдөж, ХБНГУ-ын экспортыг дэмжих үүрэг тэргүүн эгнээнд дэвшигдэн гарч ирсэн. Хүйтэн дайн, олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоо эцэс болсноор өрнөдийн орнуудын хөгжлийн бодлогод Өрнө-Дорнын сөргөлдөөн нөлөө үзүүлэхээ больж, улмаар 1990-ээд оны эхэн үед Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ОЕСД)-ийн гишүүн орнууд нь хөгжлийн бодлого бол сайн засаглал, ардчиллыг хөгжүүлэх, хүний эрхийг дээдлэх явдлыг

¹ Christian Zentner, (Hrsg.), Chronik Deutschland (von der Reichsgründung bis heute), Gallen 2007, S.484.

² Bundesministerium für wirtschaftliche Zusammenarbeit und Entwicklung, Entwicklungspolitik 2004/2005, Berlin 2004, S.32.

түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдэх ёстой гэдэг нэгдсэн ойлголцолд хүрсэн байдаг.³ Үүний дагуу 1991 онд ХБНГУ-ын Холбооны Засгийн газраас хөгжиж буй орнуудтай хөгжлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсэн нөхцөл болгож, дараах 5 шалгуурыг хангахыг шаардах болжээ. Үүнд:

- хүний эрхийг дээдэлдэг байх
- ард түмэн нь улс төрийн шийдвэр гаргахад оролцдог байх
- эрх зүйт төрийн тогтолцоотой байх
- зах зээлийн баримжаатай нийгмийн эдийн засгийн дэглэмтэй байх
- төрийн зүгээс хөгжлийн чиг баримжааг тогтоодог байх зэрэг шалгуур үзүүлэлтийг оруулсан байдаг.⁴

Монгол Улсын хувьд Өрнө-Дорнын сөргөлдөөн эцэс болсны хойно нэг намын дарангуйлал бүхий коммунист дэглэмээс татгалзаж, ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог сонгох болсны дараахан буюу 1991 онд ХБНГУ, БНМАУ-ын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааг эхлүүлсэн билээ. 2002 он хүртэлх хугацаанд Монгол Улс, ХБНГУ-ын хоёр талын албан ёсны хөгжлийн хамтын ажиллагааны төслүүд эдийн засгийн шинэчлэл, хүрээлэн буй орчин, эрчим хүч, боловсрол, нийгэм, эрүүл мэнд зэрэг бараг бүхий л салбарыг хамарч хэрэгжиж байсан нь нэг талаас Монгол Улс, ХБНГУ-ын хөгжлийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээний үеэр нэлээд хэд хэдэн чиглэлүүдийг тэргүүлэх чиглэл хэмээн үзсэнтэй холбоотой төдийгүй нөгөө талаас “1993 оны Холбооны Засгийн газрын хөгжлийн бодлогын үндсэн чиглэл” баримт бичигт, хүнс тэжээлийн хангамж ба орон нутгийн хөгжил, байгаль орчин хамгаалал, эрчим хүч, боловсрол, хүн ам зүйн бодлого зэрэг⁵ маш олон чиглэлүүдийг тэргүүлэх чиглэл хэмээн авч үзэх болсонтой холбоотой биз ээ. Хөгжлийн тусламжийг нэг улсын хувьд ийм олон чиглэлээр үзүүлдэг явдалд өөрчлөлт оруулах анхны сэжиг 1998 онд тавигдсан билээ.

³ Siegmар Schmidt, Gunther Hellmann, Reinhard Wolf (Hrsg.), Handbuch der deutschen Außenpolitik. Wiesbaden, 2007, S.675.

⁴ Uwe Andersen, Deutschlands Entwicklungspolitik im internationalen Vergleich. In: Informationen zur politischen Bildung, Nr.286/2005, S.59.

⁵ Bundesministerium für wirtschaftliche Zusammenarbeit und Entwicklung, Grundlinien der Entwicklungspolitik der Bundesregierung. Bonn 1993, S. 23-30.

Арван зургаан жилийн туршид оршин тогтносон Хельмут Колийн Христос-либераль намын эвслийн Засгийн газрын халааг 1998 онд Герхард Шредерийн тэргүүлсэн Социаль демократ-Ногооны намын эвслийн Засгийн газар авах үед ХБНГУ-ын эдийн засаг, санхүүгийн байдал ойрын түүхэнд байгаагүй их хэмжээгээр хүндэрч, 4,5 сая ажилгүйчүүдтэй, 1 биллион ДМ-ын өртэй болсны зэрэгцээ тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал, татварын тогтолцоо гацаж хямарсан, боловсролын тогтолцоо хоцрогдсон, хүнд суртал хэт их нэмэгдсэн байв.⁶ Шредерийн Засгийн газрын хөгжлийн бодлогод бүхий л салбарт хэрэгжүүлж эхэлсэн төсөв, мөнгөний хэмнэлтийн бодлого үл мөрөө тодхон үлдээснээс гадна шинэ шинэ үүрэг зорилтуудаар хөгжлийн бодлого баяжигдах болжээ. Тухайлбал, 2000 онд НҮБ-ын гишүүн орнууд Ерөнхий Ассамблейн тусгай чуулганаар 2015 он гэхэд дэлхий дээрх ядуурлыг тал хувиар бууруулах Мянганы хөгжлийн зорилтуудыг баталсныг хэрэгжүүлэх зорилгоор Холбооны Засгийн газраас 2001 онд "Үйл ажиллагааны хөтөлбөр 2015"-ийг батлан гаргасан байна.⁷ Мөн 2001 оны 9-р сарын 11-нд дэлхий нийтийг цочоосон террорист халдлагууд гарсан явдал нь хямрал, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шинэ үүргийг хөгжлийн бодлогод нэмж, улмаар хөгжлийн бодлого ядуурлын эсрэг тэмцлээс гадна терроризмын эсрэг тэмцэлд шилжиж, аюулгүй байдлын бодлогод нэгэн зэрэг үйлчлэх үүд хаалгыг нээж өгчээ.⁸

Шредерийн Засгийн газар 2000 оны 5-р сарын 19-ний өдөр Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны талаар Бундестагт мэдэгдэл хийж, шинэ зууны хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны үндсэн чиглэл, зорилтыг тодорхойлж, хөгжлийн тусламжийг аль болох цөөн тооны салбарт төвлөрүүлэн үр ашгийг дээшлүүлэх хэмнэлтийн бодлого явуулах болжээ.⁹ Энэ бодлогынхоо хүрээнд хамтран ажиллах орнуудын тоог 118-80 болгон цөөлж тунш орнуудын жагсаалтанд үлдсэн орнуудад үзүүлэх тусламжийн хэмжээг 10-30

⁶ Christian Hache, Die Außenpolitik der Bundesrepublik Deutschland, Frankfurt Main 2003, S.446-447.

⁷ Bundesministerium für wirtschaftliche Zusammenarbeit und Entwicklung, Entwicklungspolitik 2004/2005, Berlin 2004, S.164-167.

⁸ Günther Maihold, Die sicherheitspolitische Wendung der Entwicklungspolitik: Eine Kritik des neuen Profils, In: IPG 4/2005, S.30-31.

⁹ Энхтайван, Л (Санхүү, эдийн засгийн дэд сайд, доктор, профессор), "Монгол-Германы хөгжлийн хамтын ажиллагаа", Герман: Судалгаа, мэдээлэл, Улаанбаатар, 1(2002), 16-р тал.

хувь бууруулсан байна.¹⁰ ХБНГУ нь хөгжлийн хамтын ажиллагааны түнш улс орнуудыг үндсэн түнш орнууд (Үүнд, 2003 оны байдлаар Хятад, Вьетнам, Турк, Өмнөд Африк, Мозамбик, Энэтхэг, Пакистан зэрэг уламжлалт олон жилийн харилцаатай, санхүүгийн хамтын ажиллагааны томоохон төслүүдийг хэрэгжүүлдэг 40 орон багтаж байв), түнш орнууд (Үүнд, 2003 оны байдлаар Тусгаар Улсуудын Хамтын Нийгэмлэгийн дийлэнх орнууд, Тайланд, Бразиль, Иордан, Монгол зэрэг 35 улс багтаж байв), хамтран ажиллаж болзошгүй орнууд хэмээн ангилсан бөгөөд үндсэн түнш орнуудтай тэргүүлэх гурван чиглэлээр харин түнш орнуудтай зөвхөн тэргүүлэх нэг чиглэлээр хамтран ажиллах болсон билээ.¹¹

Энэхүү шинэ бодлогын хүрээнд Монгол, Германы хамтарсан комисс Монгол Улсад ХБНГУ-ын Засгийн газрын тусламжаар хэрэгжиж байгаа бүх төслүүдэд үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг 2002 онд хийсний үндсэн дээр Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны 2002/2003 оны хэлэлцээгээр хоёр орны хөгжлийн хамтын ажиллагааг

1. Эдийн засгийн шинэчлэл, зах зээлийн эдийн засгийн хөгжил (Үүнийг сүүлийн жилүүдэд тогтвортой эдийн засгийн хөгжил гэж томъёолох болсон)
2. Байгаль орчны бодлого, байгалийн нөөцийн хамгаалалт түүнчлэн сэргээгдэх эрчим хүч

гэсэн хоёр үндсэн чиглэлд төвлөрүүлэхээр харилцан тохиролцсон.¹² Өөрөөр хэлбэл, хөгжлийн хамтын ажиллагааны хэмнэлтийн бодлого ёсоор ХБНГУ нь Монгол Улстай нэг л салбарт хамтран ажиллах байсан боловч ийнхүү хоёр салбарт хамтран ажиллахаар болсон төдийгүй 2003 оны 11-р сард Улаанбаатар хотноо болж өнгөрсөн 2004 оны Засгийн газар хоорондын хэлэлцээний өмнөх зөвлөлдөөний үеэр хоёр дахь үндсэн чиглэлийн хүрээнд эрчим хүчний алдагдлыг бууруулах тал дээр хамтран ажиллахаар тохиролцсон нь хоёр талын хөгжлийн бодлогын албан ёсны хамтын ажиллагаа үндсэндээ гурван

¹⁰ Энхтайван, Л (Санхүү, эдийн засгийн дэд сайд, доктор, профессор), “Монгол-Германы хөгжлийн хамтын ажиллагаа”, Герман: Судалгаа, мэдээлэл, Улаанбаатар, 1(2002), 16-р тал.

¹¹ Uwe Andersen. “Deutschlands Entwicklungspolitik im internationalen Vergleich“, In: Informationen zur politischen Bildung, Nr.286/2005, S.60.

¹² Баттөр, Д (Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн), “Монгол-Германы хөгжлийн хамтын ажиллагаа”, Герман: Судалгаа, мэдээлэл, Улаанбаатар, 3(2004), 29-р тал.

албарт хэрэгжих боломжтой болсон ажээ.¹³

Түүнчлэн хөгжлийн тусламжийг бүс нутагт төвлөрүүлэх бодлогын хүрээнд 2003 оны хавар Монгол, Германы хамтарсан төвлөн хэсэг байгуулагдан хөдөө орон нутагт ажилласан бөгөөд уг төвлөн хэсгийн боловсруулсан саналыг үндэслэн Монгол, Германы хөгжлийн хамтын ажиллагааг Дархан-Уул аймаг, Сэлэнгэ, Орхон аймгийн зарим хэсэг болон Завхан аймаг, Говь-Алтай аймгийн зарим сумдыг хамарсан хоёр зурвас бүс нутагт төвлөрүүлэхээр харилцан тохиролцсон нь эдүгээ хэрэгжиж байна.

ХБНГУ-ын Засгийн газраас Монголд үзүүлсэн хөгжлийн албан ёсны тусламжийг хүснэгтээр үзүүлбэл:

	1991 (сая ДМ)	1992 (сая ДМ)	1993 (сая ДМ)	1994 (сая ДМ)	1995 (сая ДМ)	1996 (сая ДМ)	1997 (сая ДМ)	1998/1999 (сая ДМ)	2000/2001 (сая ДМ)	2002/2003 (сая евро)	2004/2005 (сая евро)	2006/2007 (сая евро)	Нийт 1991-2007 (сая евро)
Салхүүгийн тусламж	15	10	14	17	12	15	15	25 +17 ²	20 +8 ⁵	10	9 +9,3 ⁸	9	123,20
Техникийн тусламж /үндсэн чиглэлээр/	9	5	11	11	13	14	15	25 +3 ³	20 +6 ⁴	10 +1 ⁷	11 +1 ⁹	9,5	99,99
Дүн	24	15	25	28	25	29	30	70	54	21	24	18,5	223,19
Техникийн тусламж /бусад чиглэлээр/													30,3 ¹⁰
Нийт дүн ⁶													253,49

Эх сурвалж: 1991-2005 оны мэдээг ХБНГУ-ын Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамнаас, 2006-2007 оны мэдээг www.bfai.de сайтаас авч ашиглав.

¹³ Мөн тэнд.

- ¹ 1998 оноос эхлэн 2 жилээр амлах болсон
- ² Ерөнхийлөгч Херцогийн айлчлалын үеэр амласан: Харилцаа, холбоо II+III-т зориулж 17 сая ДМ
- ³ Ерөнхийлөгч Херцогийн айлчлалын үеэр амласан: Эдийн засгийн эрхийг түлхүү харгалзан эрх зүйн зөвлөлгөө өгөх төсөлд зориулж 3 сая ДМ
- ⁴ Засгийн газар хоорондын хэлэлцээний амлалтаас гадуур "Зуд" яаралтай тусламжийн хөтөлбөр 2 сая ДМ болон "Сэргээгдэх эрчим хүч" төсөлд зориулсан тусгай амлалт 4 сая ДМ (2000 он)
- ⁵ Засгийн газар хоорондын хэлэлцээний амлалтаас гадуурх амлалт 8 сая ДМ, "Сэргээгдэх эрчим хүч" төсөлд зориулсан тусгай амлалт (2001 он)
- ⁶ Холбооны муж улсуудын эх сурвалжийг үл оролцуулан тооцсон мөнгөн дүн
- ⁷ ХЭЗХАХЯ-ны Парламентын Төрийн нарийн бичгийн дарга У.Айдын айлчлалын үеэрх тусгай амлалт: хуулийн мэргэжилтнүүдийг давтан сургах төсөл, 1 сая евро
- ⁸ а) Дэлхий нийтэд ач холбогдол бүхий арга хэмжээнд (эрчим хүчний үр ашигтай хэрэглээ) зориулсан тусгай хөрөнгө 3 сая евро (VE 2004), б) ХАС банкинд зээл олгоход зориулж 3,0 сая (VE 2005), в) хувийн байшин барихад дэмжлэг үзүүлэх зорилгоор зээлийн хөтөлбөр 3,3 сая (VE 2005)
- ⁹ Дэлхий нийтэд ач холбогдол бүхий арга хэмжээнд зориулсан тусгай хөрөнгө (ДОХ-той тэмцэх арга хэмжээ)
- ¹⁰ Үүнд 2006, 2007 оны мэдээ тусгагдаагүй.

Хоёр. ХБНГУ-ын хоёр талын албан ёсны техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх механизм



ХБНГУ-ын хоёр талын албан ёсны хөгжлийн хамтын ажиллагаа нь аливаа хоёр улсын Засгийн газар хоорондын зохих гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр хэрэгждэг бөгөөд энэ хүрээнд хэрэгжиж буй санхүүгийн болон техникийн хамтын ажиллагааны төслүүдийн санхүүжилт нь Холбооны Засгийн газрын шийдвэрийн үндсэн дээр ХБНГУ-ын ард түмний татварын орлогоос хийгддэг билээ. Харин Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (ХЭЗХАХЯ) зохих талуудтай хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр төслүүдийг сонгож ГТХАН-д хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг буюу захиалга өгдөг. Техникийн хамтын ажиллагааны хүрээнд түнш орнуудад төслүүдийг эргэж төлөгдөхгүйгээр тусламж болгон хэрэгжүүлдэг бөгөөд Холбооны Засгийн газар хоёр талын техникийн хамтын ажиллагааг хөгжүүлж эхэлсэн 1960 оноос хойш 2002 он хүртэл нийт 18,1 тэрбум еврог энэ зорилгод ашиглах зөвшөөрлийг олгосон байна.¹⁴

ХБНГУ-ын хоёр талын техникийн хамтын ажиллагааны зорилго нь хамтран ажиллагч тухайн орны байгууллага, хувь хүмүүст ялангуяа ядуу буурай хүн амын хэсгийг онцгойлон хамруулахыг эрмэлзэн техникийн, эдийн засгийн болон зохион байгуулалтын

¹⁴ Bundesministerium für wirtschaftliche Zusammenarbeit und Entwicklung, Entwicklungspolitik 2004/2005, Berlin 2004, S.62.

мэдлэг, чадварыг дамжуулах замаар тэдгээр байгууллага, хувь хүмүүсийн чадавхийг бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх явдал ажээ.¹⁵

ХБНГУ-ын хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх асуудлыг хариуцдаг чиглэлийн яамны хувьд ХЭЗХАХЯ нь хоёр талын албан ёсны техникийн хамтын ажиллагааны төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг ихэвчлэн Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГТХАН) ХХК-д даалгадаг байна.¹⁶ Энэхүү аж ахуйн нэгж нь олон нийтийн тусын тулд ийнхүү захиалгат даалгаврыг авч хэрэгжүүлдэг бөгөөд олсон ашгаа эргээд олон улсын хамтын ажиллагааны төслүүдэд зориулдаг.

ГТХАН нь анх 1975 онд холбооны өмчийн харьяалалд хувийн аж ахуйн нэгжийн зохион байгуулалттайгаар байгуулагдсан холбооны аж ахуйн нэгж юм. 2005 оны байдлаар ГТХАН нь дэлхийн 131 оронд 2700 гаруй төслийг хэрэгжүүлж буй бөгөөд нийт 10.000 гаруй ажиллагсадтай юм. 2003 онд ГТХАН нь нийт 885 сая еврогийн гүйлгээ хийснээс бараг 80% нь Холбооны үүрэг даалгаврын дагуу хийгдсэн ажлаас, 14% нь буюу 130 сая евро нь олон улсын байгууллагууд, хувийн компаниуд, гадаад орны Засгийн газруудын зүгээс даалгасан захиалгат ажлаас тус тус орсон байна.¹⁷ Харин 2005 оны байдлаар ГТХАН-ийн нийт гүйлгээ 875 сая еврод хүрснээс 693 сая евро нь ХЭЗХАХЯ зэрэг холбооны байгууллагуудын захиалгат төсөл хөтөлбөрүүдээс орсон байна.¹⁸

ХБНГУ-ын хоёр талын албан ёсны техникийн хамтын ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх явцыг схемчлэн харуулъя.¹⁹

¹⁵ Мөн тэнд, 62-р тал.

¹⁶ Ф.Ф.Мюллер, "ХБНГУ-ын хөгжлийн хамтын ажиллагаа – Ерөнхий бүтэц ба Монгол Улс хөтөлбөр", Удо Б.Баркманн, Л.Хайсандай, Монгол-Германы харилцаа: Өнгөрсөн үе-Эдүгээ-Хэтийн төлөв, Улаанбаатар, 2004, 108-р тал

¹⁷ Uwe Andersen, "Deutschlands Entwicklungspolitik im internationalen Vergleich", In: Informationen zur politischen Bildung, Nr.286/2005, S.58.

¹⁸ <http://www.gtz.de/de/unternehmen/1732.htm>

¹⁹ Bundesministerium für wirtschaftliche Zusammenarbeit und Entwicklung, Entwicklungspolitik 2004/2005, Berlin, 2004, S.62.

Түнш орны зүгээс ХБНГУ-аас тус улсад суугаа Элчин Сайдын Яаманд хөтөлбөрийн төслөө буюу хүсэлтээ тавина.

Элчин Сайдын Яам хүсэлтэнд тайлбар бичээд, ХЭЗХАХЯ болон хэрэгжүүлэгч байгууллагуудад илгээнэ.

ГТХАН

ХЭЗХАХЯ

Байр сууриа илэрхийлнэ.

Сонголт хийнэ

Хэрэгжүүлэгч байгууллагууд болон тус яамны тухайн салбар хариуцсан ажлын хэсэгтэй хамтран хэлэлцэж, нэгдмэл байр суурьд хүрнэ.

Шалгаж, бэлтгэл хангана.

Шаардагдах хөрөнгө мөнгийг гаргахыг зөвшөөрч, олон улсын эрх зүйн тохиролцоог байгуулна.

Санал болгоно.

Үүрэг даалгавар өгнө

Хэрэгжүүлэх болон санхүүжилт үзүүлэх гэрээнүүдийг байгуулна.

Хэрэгжүүлнэ
Явцын тайлан гаргана
Эцсийн тайлан гаргана

Гурав. ГТХАН-ийн шугамаар Монгол Улсад хэрэгжсэн зарим гол төслүүдийн үндэслэл, зорилго, хийгдсэн ажлуудын тухай товч тойм

1. Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл

1990 оноос Монгол Улс зах зээлийн эдийн засаг бүхий ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжих шилжилтийг хийж эхэлсэн билээ. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсад эрх зүйн шинэтгэл хийх зайлшгүй шаардлага бий болсон байв. Үүнд:

- Хуулийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, ажлын хуваарилалтыг оновчтой болгох
- Мэргэжлийн хуульч болон хуулийн бус мэргэжилтэй ч уг салбарт ажилладаг ажилтнуудыг давтан сургалтанд хамруулж, гадаадад туршлага судлуулан ур чадварыг дээшлүүлэх талаар анхаарах
- Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх
- Эрх зүйн нэгдсэн мэдээллийн санг бий болгох
- Зах зээлийн эдийн засгийн харилцаа, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн Монголын эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгон зохицуулах
- Эрх зүй, эдийн засгийн салбарын чухал шаардлагатай хуулийн төсөл боловсруулахад дэмжлэг авах

зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байлаа.

Энэ үед Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын “Хэлэлцээрийн дүнгийн тухай” 1991 оны 6-р сарын 23-ны өдрийн Протокол болон “Техникийн хамтын ажиллагааны тухай” 1992 оны 1-р сарын 29-ний өдрийн хэлэлцээрийн дагуу ХБНГУ-ын ХЭЗХАХЯ (Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Яам)-ны даалгавраар Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн салбарт хамтран ажиллах, эрх зүйн шинэтгэлийг цогц утгаар нь хэрэгжүүлэх зорилгоор ГТХАН нь 1995 оноос эхлэн Монгол Улсын хууль зүйн салбарт төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү хамтын ажиллагаа 2008 онд 13 дахь жилдээ үргэлжилж байна. ГТХАН-ийн Хуулийн төсөл

1995 оны 5-р сараас 2003 оны 8-р сар хүртэл “Монгол Улсын эдийн засгийн эрх зүйн шинэтгэл”²⁰ 2003 оны 8-р сараас 2008 оны 8-р сар хүртэл “Хуульчдын сургалт ба давтан сургалт”, 2008 оны 8-р сараас 2011 оны 4-р сарын хооронд “Эдийн засгийн тогтвортой өсөлтийн эрх зүйн орчинг баталгаажуулах” төсөл гэсэн нэрээр тус тус нэрлэгдэж байна. Монголын эдийн засгийн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх зорилготой эдийн засгийн үндсэн зарчимд нийцүүлэн өөрчлөхөд төсөлчлөг үзүүлэх зорилготой эдгээр төслийн хүрээнд хуулийн төсөл боловсруулахад зөвлөгөө өгөх, хуульчдыг сургах, давтан сургах, хуулийн байгууллагын бүтэц зохион байгуулалтад зөвлөгөө өгөх, эрх зүйн сурталчилгаа болон эрх зүйн судалгаа гэсэн чиглэлүүдээр үйлчилгээг явуулсан байна. Тус төслөөс үндсэн чиглэлүүдийнхээ хүрээнд өнгөрсөн хугацаанд хийж бүтээсэн ажлуудынх нь талаар ойлгомжон хүргэхэд²¹

- Юуны өмнө Монгол Улсын Хууль зүйн яам болон УИХ-д 30 гаруй хуулийн төсөлд зөвлөгөө өгснөөс Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль (1997), Хууль, УИХ-ын бусад шийдвэрийг боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль (1997), Хоршооны тухай хууль (1998), Хөдөлмөрийн хууль (1999), Иргэний хууль (2002), Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2002), Газрын тухай хууль (2002), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002), Арбитрын тухай хууль (2002), Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2002), Хуульчдыг сонгон шалгаруулах журмын тухай хууль (2002) зэрэг 14 хууль нь УИХ-аар батлагджээ. Мөн Иргэний хуулийн болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн шинжлэх ухааны тайлбаруудыг тус

²⁰ 4,35 сая еврогийн өртөгтэй хэрэгжсэн төсөл - Projektliste Mongolei, im Stand August 2005, BMZ.

²¹ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Rechtsberatung mit Schwerpunkt Wirtschaftsrecht, GTZ.-Office Ulaanbaatar, S. 13-16; Die GTZ in der Mongolei. Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne, Aus- und Fortbildung von juristischem Fachpersonal, GTZ GmbH, Ulaanbaatar, 2006, S.15-16; Хөхтөмөр, Э., “Монголд хэрэгжсэн хамгийн өгөөжтэй төсөл”, Өнөөдөр, 2007.11.15. №268(3226); Хөхтөмөр, Э., “Хуулийн төсөл боловсруулах нь хамгийн харууцлагатай ажил”, Өнөөдөр, 2007.11.29. №279(3237); Хөхтөмөр, Э., “Давтан сургалт энгийн ойлгомжтой байхыг эрхэмлэдэг”, “Хууль эрх зүйн сурталчилгаанд шинэчлэлийн салхи авчирсан төсөл”, Өнөөдөр, 2007.12.06, №285(3243); ГТХАН-ийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын материал, Улаанбаатар, 2008.

төслөөс болон УДШ (Улсын Дээд Шүүх)-ийн Иргэний Танхимаас гаргажээ.

- Түүнчлэн хуульчдад зориулсан сургалтын хүрээнд 1996 оноос эхлэн Монголын нийт шүүгч нарт зориулсан сургалтуудыг тогтмол явуулж, нийтдээ 8 удаагийн тойргийн сургалтад Монголын бүх шүүгчдийг хамруулсан ба нийт 13 шүүгч багц тус төслөөс бэлтгэгдсэн байна. Мөн 7 прокурор – багшийг бэлтгэж, прокуроруудад зориулан 2 удаагийн тойргийн сургалтыг зохион байгуулсан. 2004 оноос эхлэн Монголын нийт нотариатч болон шийдвэр гүйцэтгэгч нарт зориулсан сургалтуудыг 4 жил дараалан зохион байгуулсан бөгөөд 4 шийдвэр гүйцэтгэгч – багшийг бэлтгэсэн байна. Хууль Зүйн Үндэсний Төвийн ажилтнуудад зориулсан сургалтыг 2006 оноос эхлүүлжээ.
- Хуулийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтанд зөвлөгөө өгөх чиглэлээр Үл Хөдлөх Эд Хөрөнгийн Бүртгэлийн Газрыг /хуучин нэрээр/ анх үүсгэн байгуулахад нь тус байгууллагыг байгуулах хуулийн төсөл боловсруулахаас эхлээд байгууллага бие даан үйл ажиллагаагаа явуулах хүртэлх бүхий л явцад зөвлөгөө өгч хамтран ажилласан байна. Мөн шүүхийн бүтэц, зохион байгуулалтад зөвлөгөө өгөх хүрээнд Сонгинохайрхан зэрэг хэд хэдэн дүүргийн шүүхүүдэд “Загвар шүүх” дэд төслийг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд шүүгч, прокуроруудын өдөр тутмын ажилд зориулсан “Judge” болон “Prosecutor” зэрэг программ хангамжуудыг боловсруулсан байна. Энэхүү программ хангамжуудыг АНУ-ын Олон Улсын Хамтын Агентлагаас хэрэгжүүлж буй Шүүх эрх мэдлийн шинэтгэл хөтөлбөртэй хамтран орон нутгийн шүүх, прокурорын бүх байгууллагуудад хэрэгжүүлсэн.
- Эрх зүйн сурталчилгааны ажлын хүрээнд 1997 оноос эхлэн “Хуулийн цаг” нэвтрүүлгийг ард иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор тогтмол нэвтрүүлсээр ирсэн бөгөөд 2005 оноос уг нэвтрүүлгийг телевизийн олон ангит жүжиг хэлбэрээр илүү сайжруулан олон нийтэд хүргэж эхэлсэн бөгөөд 2007 оныг дуустал 200 орчим ангийг ТВ-9 телевизээр гаргасан. Түүнчлэн “Дэнс” телешүүх, “Хууль таны амьдралд”, “Таны хуулийн мэдлэг”, “Хуульчийн цаг” зэрэг телевиз, радиогийн нэвтрүүлгүүдийг бэлтгэн МҮТВ, Монголын радио,

МН-25 болон С-1 телевизүүдээр олон нийтэд хүргэсэн байна. Хөдөө, орон нутгийн эрх зүйн сурталчилгааг дэмжих зорилгоор "Эрх зүйн сурталчилгааг орон нутагт хэрэгжүүлэх" нь сэдэвт Мини-төслүүдийг давхардсан тоогоор 13 аймагт хэрэгжүүлсэн байна.

- Мөн түүнчлэн Хуулийн цахим сан болон хуулийн байгууллагуудын нэгдсэн вэб хийх ажилд дэмжлэг үзүүлснээс гадна иргэний ба аж ахуйн эрх зүйн чиглэлийн 40 орчим ном, товхимол, 10-аад сонин, сэтгүүлийг эрхлэн гаргасан. Монголын хууль, эрх зүйн салбарын хамгийн том сэтгүүл болох "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийг цаашид бие даан үйл ажиллагаагаа явуулах чадвартай болоход нь дэмжих үүднээс 2 жил гаруй хугацаанд хамтран ажилласан байна. Мөн олон тооны семинар, симпозиум, эрдэм шинжилгээний бага хурлууд зохион байгуулснаас гадна УИХ, ХЗДХЯ (Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам), УДШ, УЕПГ (Улсын Ерөнхий Прокурорын Газар) болон бусад хуулийн байгууллагын удирдлага ажилтнуудын ХБНГУ-д хийх айлчлал, сургалт, семинарыг зохион байгуулсан байна.
- Төслөөс хийж гүйцэтгэсэн ажлаа дүгнэх, үр дүнг нь тодорхойлох зорилгоор болон хуулийн байгууллагуудын захиалга хүсэлтээр хууль, эрх зүйн салбарын хүрээнд социологийн судалгаа шинжилгээний томоохон ажлуудыг социологийн судалгааны байгууллагуудтай хамтран гүйцэтгэж, санхүүжүүлж байв.

ГТХАН-ээс Монгол Улсын хууль зүйн салбарт хэрэгжүүлж буй төсөл нь үндсэндээ Монголын хуулийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах болон ажилтнуудынх нь мэдлэг, чадварыг дээшлүүлэх ажилд бүрэн хэлбэрээр зөвлөгөө өгч, хамтран ажиллахад чиглэдэг бөгөөд мөн энэхүү хамтын ажиллагааг тогтмол үр дүнтэйгээр хадгалахыг гол зорилгоо болгодог.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газархоорондын 2007 оны 9-р сарын Зөвлөлдөх уулзалт ба Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны тухай 2008 оны 4-р сарын хэлэлцээний дагуу ГТХАН-ээс Монгол Улсын ХЗДХЯ-тай хамтран 2008 оны 5-р сараас 2011 оны 4-р сарын хооронд "Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах" нэртэй төслийг шинээр

эхлэн хэрэгжүүлэхээр болсон билээ. Уг төслийг ГТХАН нь ХЗДХЯ болон УДШ, УЕПГ-тай тус тус хамтран хэрэгжүүлнэ. Уг төслийн санхүүжилтэнд зориулан ХБНГУ-ын Засгийн газраас 2,5 сая хүртэлх евро олгохоор болжээ.

Энэхүү төслийн үндсэн зорилго нь хууль, эрх зүйн бодлого ба шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаагаар дамжуулан зах зээл болон улс төрийн хэвшмэл харилцан нөлөөг зааглан зохицуулахад чиглэж байгаа бөгөөд энэхүү зорилгын хүрээнд эхний үе шатанд хууль, тогтоомжийн боловсруулалт болон хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн арга барилыг нэвтрүүлэх зорилттойгоор ажиллах юм.

Дээрхи зорилго, зорилтын дагуу төслийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, иргэний болон эдийн засгийн чиглэлийн хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, хуулийн байгууллагуудын мониторингийн тогтолцоог бүрэлдүүлэхэд зөвлөгөө өгч, хамтран ажиллахад чиглэнэ.²²

2. Хөдөө орон нутагт санхүүгийн тогтолцоог бий болгох төсөл

1996 оны 2-р сараас 2003 оны 1-р сар хүртэл Санхүү, Эдийн Засгийн Яам (СЭЗЯ)-тай хамтран Хөдөө Аж Ахуйн Банк (ХААН) дээр хэрэгжүүлсэн 4,6 сая еврогийн өртөгтэй²³ төсөл юм.

1990-ээд оноос Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдлийн мэдэлд байсан төрийн болон төржсөн хоршооллын өмчийг хувьчилж түүний оронд хувийн мал бүхий малчин өрхүүд бий болж, тэдэнд орлогоо нэмэгдүүлэхүйц үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх шаардлага тулгарсан. Энэ асуудлыг шийдвэрлэх гол арга зам нь санхүүгийн зөв боловсронгуй тогтолцоогоор дамжуулан малчдад зээл олгох явдал байв. Малчдын зээлийн хэрэгцээ мал аж ахуйн үйлдвэрлэл /өвс тэжээл, мал эмнэлэг, худаг хашаа бэлтгэх/-д түлхүү чиглэгдэж байв. Малчид зээлийн барьцаанд мал, үнэт эдлэл, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, өвөлжөө, хаваржаа, сумын төвийн хашаа байшин, ногооны газар, түүхий эдээ барьцаалан зээл авах

²² ГТХАН-ийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын материал, Улаанбаатар, 2008.

²³ Projektliste Mongolei, im Stand August 2005, BMZ.

сонирхолтой байсан ч тэдэнд зээл авах банк-санхүүгийн тогтолцоо хэдөө орон нутагт бүрэлдэж бий болоогүй байлаа. Мөн тухайн үед банкны салбарууд хэдөө орон нутагт тогтвортой ажиллахад гарч байсан нэг хүндрэлтэй асуудал бол малыг хөрөнгийн баталгаа болгохоос татгалзаж байсан явдал юм.

Дэлхийн Банкнаас гаргасан *Бодлого судлалын баримт бичиг*-т дүрдснаар Монголд малын хорогдол түгээмэл, байгалийн хүндрэл болон малын өвчлөл богино хугацаанд их эрсдэл авчрахаас гадна ажлын явцад сөрөг нөлөө бий болгодог. Энэ нь Монголын банкны салбарынхан малчдад зээл олгохоос татгалзах хамгийн гол шалтгаан болдог тухай тэмдэглэжээ. Иймээс хөдөөгийн сумдын малчид мал ахиульгаа хөтлөн явуулж, амьжиргаагаа дээшлүүлэхэд нь тэдэнд нүүрээ буруулдаггүй санхүүгийн байнгын үйлчилгээ хэрэгтэй байв.

Энэ төслийн гол зорилго нь хөдөө орон нутагт ядуурлыг бууруулж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн хувийн компаниуд, жижиг, дунд үйлдвэр, малчдад санхүүгийн үйлчилгээг үзүүлэх чадвартай орчин үеийн банкны систем бий болоход дэмжлэг үзүүлэх явдал байсан. Иймийн тулд,

- Нийт 300 орчим салбартай, улс даяар салбарууд нь жигд тархсан ХААН банкыг сонгон авч түүнийг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх чадвартай олон улсын стандартын банк болгохоор энэ төслийн хүрээнд бүтцийн өөрчлөлт хийх болсон. Төслийн зүгээс ХААН банкны удирдлага болон Төв Банк, СЭЗЯ-тай зөвлөлдөн тохирсны үндсэн дээр тус банкинд бүтцийн өөрчлөлт хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, зарим хэсгийг хэрэгжүүлсэн. 2000 оны дунд үеэс USAID-ийн санхүүжилтээр 5 гишүүн бүхий менежментийн баг Төв Банктай хамтран ХААН банкны бүтцийн өөрчлөлтийг удирдах болж, ГТХАН зээлийн менежментийн чиглэлд зөвлөгөө өгөхөд анхаарах болжээ.
- ХААН банкнаас зээл олгох үйл ажиллагааны бэлтгэл ажлын хүрээнд нэгдүгээрт, бүх шатны ажилтан нарт шаардагдах сургалтыг зохион байгуулсан. Жишээлбэл, банкны төвийн болон салбарын захирал нарт орчин үеийн, зах зээлийн эдийн засгийн менежментийн арга барилд сургах, бизнес төлөвлөгөө

3. Санхүүгийн салбарын үйлчилгээ үзүүлэгч нарт дэмжлэг үзүүлэх төсөл

2005 оны 1-р сараас 2007 оны 7-р сар хүртэл 1,022 сая еврогийн өртөгтэй²⁵ хэрэгжсэн төсөл юм.

1990-ээд оны сүүлч үеийн хямралыг Монголын банкнууд даван туулсны дараа тэд дахин сэргэж, хурдтай урагшлан хөгжих болсон ч санхүүгийн салбарын ажилтан нарын мэргэжлийн төвшин доогуур байгаа нь тус салбарын цаашдын хөгжлийг хойш татагч бас нэгэн хүчин зүйл болж байлаа. Энэ нь цаашлаад захиргааны өндөр зардал, эрсдэлээс хамгаалах ихээхэн өртөг бүхий арга хэмжээ зэргээр дамжин банкны зээлийн хүү өндөр байхад нөлөөлж байв.

Иймд өмнө хэрэгжсэн "Хөдөө орон нутагт санхүүгийн тогтолцоог бий болгох төсөл"-ийн явцад хуримтлуулсан туршлагад тулгуурлан санхүүгийн салбарын эл тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр "Санхүүгийн салбарын үйлчилгээ үзүүлэгч нарт дэмжлэг үзүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэхээр болжээ. Уг төслөөр Банкны Сургалтын Төв (Bank Training Center)-ийг Монголын санхүүгийн салбарт банкны сургалтын үйлчилгээ үзүүлэгч гол байгууллага болгон төлөвшүүлэхийг зорилгоо болгосон.²⁶

Энэхүү төв нь санхүүгийн салбарт үйлчилгээ үзүүлэгч гол байгууллага болохын хувьд санхүүгийн олон байгууллагуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн төрөл бүрийн сургалт, хөтөлбөрүүдийг зохион байгуулжээ. Тухайлбал, 2007 оны 5-р сард Банкны сургалтын төв, Банкны холбоотой хамтран Монголын арилжааны 16 банкны гүйцэтгэх захирлуудыг ХБНГУ-ын Потсдам хотод болсон "Ерөнхий менежментийн хөтөлбөр"-т хамруулж, банкны стратеги, санхүүгийн харилцаанд тулгуурласан банкны менежмент, эрсдлийн менежмент, борлуулалтын менежмент, харилцаа холбоо, банкны ёс зүй, манлайлан удирдах зэрэг сэдвээр хичээл заажээ. Мөн энэ төслийн хүрээнд банкны байгууллагуудын 12 ажилтан харилцагчидтай хэрхэн харилцаа холбоогоо хөгжүүлэх, нөхцөл байдалд тохируулан хандлага, арга барилаа сонгох талаар 3 долоо хоногийн сургалтанд

²⁵ Die GTZ in der Mongolei, Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne. Förderung von Dienstleistern im Finanzsektor, GTZ GmbH, Ulaanbaatar 2006, S.9-10.

²⁶ Die GTZ in der Mongolei, Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne. Förderung von Dienstleistern im Finanzsektor, GTZ GmbH, Ulaanbaatar 2006, S.9-10.

хамрагдсан байна. Сургалтанд хамрагдсан 12 хүн цаашид сурч мэдсэнээ өөрсдийн банкны ажилтнуудад заах үндэсний боловсон хүчин болж байгаа бөгөөд цаашдын сургалт, семинарынхаа үзэл баримтлалыг боловсруулах, бие даан сургалт явуулах чадвартай болжээ.²⁷

4. Хөдөө орон нутагт өөрөө өөртөө туслах нэгжийг дэмжих төсөл

1998 оноос 2004 оны 12-р сар хүртэл Монгол Улсын Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам (ХХААЯ)-тай хамтран Завхан, Баянхонгор, Дорноговь, Баян-Өлгий аймгуудад хэрэгжүүлсэн 4,3 сая еврогийн өртөгтэй²⁸ төсөл юм.

Хөдөө орон нутагт олон жилийн туршид улсаас төвлөрсөн удирдлагаар хангагдаж, санхүүгийн шууд дэмжлэгтэй явж ирсэн 200 гаруй нэгдэл, сангийн аж ахуйнууд тарснаар малчдыг аж ахуй зохион байгуулалтын хувьд нэгтгэж байсан бүтэц 1990 оны эхэн үед үгүй болжээ.

Малчид түүхий эд, бүтээгдэхүүнээ борлуулахдаа өөрсдөө төвлөрсөн зах зээлд авчирч зарах, эсвэл төвөөс ченжүүд ирж авахыг хүлээх үндсэн хоёр хэлбэртэй болсон төдийгүй цөөн малтай малчид голчлон зээлээр авсан хүнс, өргөн хэрэглээнийхээ барааны төлбөр түүхий эдээ өгдөг байв. Харин хөдөөгийн ард иргэд хэрэгцээ бараа бүтээгдэхүүнээ худалдаж авахдаа явуулын худалдаачдыг харсан хоцрогдмол байдалтайгаар амьдарч байсан бөгөөд тэдгээр худалдаачид нь өөрсдийн ашгийг гол болгож, малчдын эрэлт хэрэгцээг хангахуйц чанартай бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж чадахгүй байв. Уг нь малчид зохион байгуулалттайгаар нэгдэж нийлээд түүхий эдээ зах зээлд үнэ хүргэж, цаашилбал бүтээгдэхүүн үйлдвэрлэж болох байтал орон нутгийн хөгжилд нь нэмэр болохгүй тэдгээр худалдаачдыг дэмжиж арилжаа хийсээр байв.

Малчид хоршиж ажиллах хэрэгцээгээ улам бүр мэдэрч байсан ч төдийлөн амжилт олж чадахгүй байсан нь:

²⁷ Хөхтөмөр, Э., “Хөгжинэ гэдэг хүнээ хөгжүүлнэ гэсэн үг”, Өнөөдөр, 2007.06.25 №148(3106).

²⁸ Projektliste Mongolei, im Stand August 2005, BMZ.

- Малчдын эдийн засгийн мэдлэг дутмаг
- Хоршижажиллахад эрх зүйн болон удирдлагын арга туршлага хомс
- Шинэ маягийн хоршооны ойлголт төлөвшөөгүй
- Хоршооллын нэгдсэн бодлого, хэрэгжүүлэх бүтэц байхгүй зэрэг нөхцөл байдалтай холбоотой байжээ.

Иймд энэхүү төслийн хүрээнд сонгож авсан аймгуудад малчид болон сумын төвийн иргэдийн дунд бараа бүтээгдэхүүнийг борлуулах, худалдан авах бүтцийг бий болгоход нь туслалцаа үзүүлж улмаар төдий эдийн засаг, нийгмийн байдлыг сайжруулахын тулд малчид ба сумын төвийн иргэдийн дунд өөрөө өөртөө туслах байгууллага болох хоршоо байгуулагдахад дэмжлэг үзүүлэх зорилгыг тавьсан байна. Үүний тулд хийгдсэн гол ажлуудыг дурдвал:

- ГТХАН-ийн “Эдийн засгийн эрх зүйн салбарт зөвлөгөө өгөх төсөл”-ийн хүрээнд олон улсын стандартад нийцсэн Хоршооны тухай хууль батлагдан гарсан нь уг төсөл хэрэгжих угтвар таатай нөхцлийг бүрдүүлсэн байна. Энэхүү хууль эрх зүйн нөхцлийг улам сайжруулахын тулд 1998 оноос мөрдөж байсан Хоршооны тухай хуульд 2002 оны 12-р сард нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахад хоршоодын холбоодтой хамт гол үүрэг гүйцэтгэж ХЗХ-ын зохицуулалтуудыг энэхүү хуульд анхлан санаачилж оруулсан.
- Шинээр байгуулагдсан хоршоод цаашид хөл дээрээ тогтон босоход нь эхний ээлжинд туслах зорилго бүхий хоршоодын холбоод нь төсөлд хамрагдан, гишүүн хоршоодод зөвлөгөө өгөх, сургалт явуулах, санхүүгийн үйлчилгээг ойртуулахыг эрмэлзэх болжээ. Төсөл хэрэгжсэний үр дүнд хоршоодын холбоодын удирдлага чадваржиж, гишүүн байгууллагууддаа үзүүлэх үйлчилгээний төрөл олширч, чанар сайжирсан ажээ.
- Хоршоодын холбоодын чадварыг нэмэгдүүлэх, хоршооллын сургалт мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгохын тулд 7 хоршоодын холбоод дундаас 1998 оны 12-р сард Үндэсний хоршоодын сургалт, боловсролын төвийг байгуулсан. Уг төвийг хоршоодод сургалт явуулах чадвартай болгохын

тулд шаардагдах бүхий л арга хэмжээг төслийн хүрээнд авч хэрэгжүүлсэн байна. Үүнд, 7 хоршоодын холбооны 50 сургагч багш нарыг 4 үе шаттайгаар сургалтанд хамруулж, тус төвийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хуваарийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Тус төвөө сургалт, мэдээллийн материалыг сонгож, худалдан авахад дэмжлэг үзүүлсэн. Мөн тус төвийн болон бусад хоршоодын холбооны гишүүдээс ХБНГУ-д явуулж, мэдээлэл, сургалтанд хамруулсны зэрэгцээ Ханой, Бээжин, Бангкок хотноо болсон хоршоодын олон улсын чуулганд оролцуулжээ.

- Төслийн хүрээнд бэлтгэгдсэн хоршоодын холбооны сургагч багш нар хоршоодын гишүүдэд мэдлэгээ цааш дамжуулах болсон байна. Үндэсний сургалт, боловсролын төв нь нийт 22 аймгийн 91 суманд 778 удаагийн сургалтыг хоршоодын 20700 гишүүний дунд шууд зохион байгуулсны дүнд хоршоодын гишүүн малчдын үйлдвэрлэлийн эдийн засгийн арга ажиллагааны тухай мэдлэг нь сайжирсан байна. Баянхонгор аймгийн зарим хоршоодод бизнес төлөвлөгөөг хэрхэн зохиох талаар тусгайлан зөвлөгөө өгснөөс гадна бусад ганц нэг хоршоодод ч мах, ноос боловсруулах талаар зөвлөгөө өгсөн. Үүнээс гадна хоршоодын сургагч багш нар хоршооны тухай нэвтрүүлэг бэлтгэж, долоо хоног тутамд 2 удаа (төсөл эхэлснээс хойш нийт 120 удаа) Монголын радио, Шинэ эрин радиогоор нэвтрүүлсэн байна.
- Импорт, экспортын ажил хэргийн холбоог ялангуяа Оросын түншүүдтэй тогтооход нь хоршоодын холбоог дэмжсэн. Улаанбаатар хотноо зохиогдсон “Германы эдийн засгийн өдрүүд”-эд хоршоодын холбоо оролцох бэлтгэлийг хангаж өгсөн. Мөн төслийн зүгээс хоршоодын холбоодод жижиг зээлийн фонд байгуулах замаар хоршоодод дэмжлэг үзүүлжээ.

Төсөл хэрэгжсэний үр дүнд төрийн зүгээс хоршооллын салбарт анхаарлаа онцгойлон хандуулж Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр /ХХНХХ/ боловсруулж, 1998 оноос хойш жил болгон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хоршооллын салбарыг дэмжих үйл ажиллагаа тусгагдаж ХХНХХ-ийн Үндэсний

Төсөл нь хоршоодын холбоод, МХСМТ(Монголын Хоршоологчдын Сургалт Мэдээллийн Төв)-тэй хамтран үйл ажиллагааг хэрэгжүүлж бүтэн зэрэгцээ 2003 оныг хоршооны жил болгон зарласан байна.

Төсөл нь шинэ маягийн хоршооны ойлголтыг төлөвшүүлэхэд өндөр хувь нэмэр оруулсан. Үүний үр дүнд хоршооны зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах хоршоодын тоо нэмэгдэж, орон нутагт хоршоо нь ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг өргөжингүүлэх, ядуурлыг бууруулах нэгэн арга хэрэгсэл болсон.²⁹

5. Монголын хоршооллын байгууллагуудын менежментийг сайжруулах төсөл

2005 оны 2-р сараас 2009 оны 1-р сар хүртэл 2,0 сая еврогийн санхүүжилттэй хэрэгжиж буй төсөл юм.

1998 онд Хоршооны тухай хууль батлагдаж, “Хоршоог хөгжүүлэх үндэсний хэмжээний хөтөлбөр” /ХХНХХ/ хэрэгжиж эхэлснээс хойш хоршооны салбарын хөгжил эрс түргэссэн ч хоршооны гишүүдэд тусгайлан давуу талыг авчрах, хоршоодын гишүүдийг бүс нутгийн эдийн засгийн хөгжилд илүүтэй татан оролцуулах тал дээр хоршоодод менежмент дутагдаж байлаа. Иймд “Хөдөө орон нутагт зохион байгуулалттай өөрөө өөртөө туслах үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн үр дүн, хуримтлуулсан туршлагад тулгуурлан хоршооны цаашдын хөгжлийн дэмжихийн тулд “Хоршоодын байгууллагын менежментийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэхээр болжээ.

Уг төслөөс сонгож авсан хоршоодын байгууллагуудын менежментийг сайжруулахыг зорилгоо болгосон байна. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд 10 аймгийн 30 хоршоог сонгон авч, хоршоодын тоо, тэдгээрийн гишүүдийн тоо, ажиллагсад, гүйлгээ, орлогын бүтэц, татвар төлөлт, гадаад санхүүжилтийн эх үүсвэр зэрэг хоршоодын хамгийн чухал мэдээллийг цуглуулсан байна. Төслийн хүрээнд хийгдсэн ажлуудыг дурдвал:

²⁹ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Förderung der organisierten Selbsthilfe im ländlichen Raum. GfZ.-Office Ulaanbaatar, S. 37-40; ГТХАН-ийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын материал, Улаанбаатар, 2008.

- Хоршооны эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох чиглэлээр ХХНХХ-ийн болон бусад байгууллагуудын зүгээс санаачилсан ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, зөвлөмж, нэмэлт өөрчлөлтүүдийг бусад хоршоо дэмжигч байгууллагуудтай хамтран боловсруулахад зөвлөгөө өгсөн.
- Монголын хоршооллын сургалт мэдээллийн сүлжээг бэхжүүлэн, үйл ажиллагааг нь зөвлөх үйлчилгээгээр өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. Энэ арга хэмжээний хүрээнд хот, хөдөөгийн нийт 60 гаруй зөвлөгч нарыг 3 үе шаттайгаар бэлтгэсэн билээ.
- Үүний сацуу сонгож авсан хоршоодыг гишүүддээ менежментийнх нь нөөц бололцоог нэмэгдүүлэх үйлчилгээг санал болгох чадвартай болоход нь дэмжлэг үзүүлэхийн тулд тусгайлан сургаж бэлтгэсэн 60 зөвлөгчийн тусламжтайгаар хоршоодод ганцаарчлан менежментийн зөвлөгөө өгч эхэлсэн. Үүнээс 8 аймгийн хоршоодод менежментийн зөвлөгөө өгөх явцыг бүтээгдэхүүний технологи, маркетингийг сайжруулах явдалтай хэрхэн хослуулж болохыг бодит амьдрал дээр туршин үзүүлэхээр бэлтгэж байна. Сонгож авсан 20 хоршооны дунд хоршоодод өгч буй зөвлөгөө болон цаашид шаардагдаж буй мэргэжлийн сургалтын талаар санал асуулга явуулсны дараа хоршоодод зөвлөгөө өгөх албаны бүтэц, менежментийн талаар баримтлах стратегийг тогтоох болно.
- Сонгож авсан хоршоодоороо үлгэрлэн Монголын хоршооны салбарт системчилсэн зөвлөгөө өгөх: Үүнд хуулийн төсөл, журамд зөвлөгөө өгөхөөс эхлээд хоршоодын холбоо байгуулах, сүлжээг бий болгох тухай асуудлыг оролцуулан үйлдвэрлэлийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх хүртэл асуудлыг хамрах болно.³⁰

³⁰ Die GTZ in der Mongolei. Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne. Verbesserung des Managements der genossenschaftlichen Organisationen, GTZ GmbH, Ulaanbaatar 2006, S.27-28.

6. Төрийн хянан шалгах байгууллагыг бий болгох төсөл

1998 оны 3-р сараас эхлэн 2004 оны 12-р сар хүртэл Монгол Улсын Төрийн Өмчийн Хороонд 2,56 сая еврогийн өртөгтэй³¹ өргөгжсөн төсөл юм.

Энэ төслийн хүрээнд Монголын Төрийн өмчийн хорооны түгээс улсын төсөв, улсын өмч хөрөнгөнд тавих хяналт шалгалтыг сайжруулахыг зорилгоо болгож байв. Чингэх шалгаан нь,

Нэгдүгээрт, зах зээлийн эдийн засаг бүхий ардчилсан оронд улсын төсөвт тусгагдсан хөрөнгийг дүрэм ёсоор ашигласан эсэхийг хянах нь зайлшгүй чухал байсан тул 1995 оны 3-р сард Төрийн хяналт шалгалтын тухай шинэ хуулийг гаргасан нь Монголд төрийн өмчийн хороодыг байгуулах эрх зүйн үндсийг тавьсан билээ. Гэвч Төрийн өмчийн хороод боловсон хүчний хувьд ч, дэд бүтцийн хувьд ч хуучин тогтолцооны байгууллагын бааз суурь дээр цаашид тулгуурлах боломжгүй байсан учраас төрийн хянан шалгагчдын мэргэжлийг дээшлүүлэх, байгууллагын бүтэц, арга ажиллагааг сайжруулах, түүний эрх зүйн үндсийг улам боловсронгуй болгох, техник тоног төхөөрөмжөөр хангах, гүйцэтгэх ба хууль тогтоох байгууллагуудыг хянах байгууллагуудын хооронд ажил үүргийн заагийг тодорхой нэрлэж, нарийн хуваарилах шаардлагатай байв.

Хоёрдугаарт, Монголын Засгийн газар, Парламентын 1997 оноос хийж эхэлсэн төсөв, захиргааны өргөн цар хүрээтэй, New Public Management-д шилжих шинэчлэлийн хүрээнд Төрийн өмчийн хороо нь юуны өмнө өөрийгөө шинэчлэх, цаашлаад бусад олон нийтийн салбарын шинэчлэлийн хэрэгжилтийг шалгах, хянах шаардлагатай тулгарсан байв.

Гуравдугаарт, Төрийн өмчийн хороод улсын төсөв, хөрөнгийн орлого, зарлагын хяналтаа сайжруулах нь авилгал, хээл хахуультай тэмцэх, урьдчилан сэргийлэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад чухал ач холбогдолтой байлаа.

Төслийн хүрээнд нэн тэргүүнд Төрийн өмчийн хороодын хяналт шалгалтын үйл ажиллагааг олон улсын стандартад ойртуулах

³¹ Projektliste Mongolei, im Stand August 2005, BMZ.

зорилгоор ажилтан нарын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх явдлыг чухалчилсан бөгөөд үүний тулд зөвлөгөө өгөх, богино хугацааны мэргэжилтэн илгээж сургалт зохион байгуулах, мэргэжил дээшлүүлэх семинар явуулах, мэдээллийн болон сургалтын аялал зохион байгуулах, монгол сургагч нарыг тусгайлан бэлтгэх арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна. Тухайлбал,

- Ардчилсан улс дахь санхүүгийн хяналт; олон улсын нягтлан бодох бүртгэл; аудитын стандарт, улсын татаас, хандивын зарцуулалтыг шалгах; хээл хахууль, авилгалын мөн чанар, түүнтэй олон нийтийн захиргааны салбарт тэмцэх зэрэг сэдвээр төрөл бүрийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг хянан шалгагч нарт зориулж Монгол Улс болон ХБНГУ-д зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.
- Төрийн өмчийн хорооны удирдлага, УИХ-ын холбогдох хороод, бусад холбогдох Засгийн Газрын байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий хүмүүсийг оролцуулан мэдээллийн айлчлалыг 2 удаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.
- Олон нийтийн салбарын менежмент ба санхүүгийн бичиг баримт, төсөв болон кассын тогтолцоо, авилгалтай тэмцэх хууль зэрэг олон асуудлаар ХБНГУ-ын Хессен мужийн Төрийн хянан шалгах хорооноос зөвлөгөө авах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.

Төрийн өмчийн хянан шалгагч нар төслийн хүрээнд олж авсан шинэ мэдлэгээ өдөр тутмын практик амьдрал дээр хэрэгжүүлэхэд нь дэмжлэг тусалцаа үзүүлэх явдал энэ төслийн дараагийн шатны зорилт байлаа. Жишээлбэл, Төрийн өмчийн хорооноос УИХ-д тавих тайлан, зөвлөмжийг өндөр төвшинд бэлтгэх; төсвийг нэгтгэн дүгнэх, үр ашгийн тооцоо гаргах, хянан шалгах аргачлал улам бүр стандарчилагдаж, компьютерчлэгдэж байгаа энэ цаг үед хянан шалгагч нарт мэдээллийн технологи, компьютер ашиглалтыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, техник тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах; Төрийн өмчийн хороодын эрх зүйн байдлыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.³²

³² Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001. Aufbau einer Rechnungskontrollbehörde, S. 23-26.

7. Монгол Улсын газрын менежмент ба санхүүгийн кадастр төсөл

2005 оны 1-р сараас 2008 оны 3-р сар хүртэл хэрэгжсэн 2,0 сая еврогийн өртөг бүхий төсөл юм. Төслийн хоёр дахь үе шат нь 2008 оны 4-р сараас 2010 оны 12-р сар хүртэл 1,5 сая еврогийн өртөгтэй үргэлжилнэ.

1992 оны Үндсэн хууль, 1994 онд батлагдсан Газрын тухай хууль, мөн хуулийн 2002 оны шинэчилсэн найруулга, 2003 онд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, улсын, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журам тус тус батлагдсанаар Монгол Улсад газрын харилцааны шинэ зарчим хэрэгжиж эхэлсэн байна. Өнөөгийн байдлаар газрын харилцааны асуудал нь хууль, эрх зүйн хувьд баталгаажиж зохицуулагдаж байгаа ч шилжилтийн үеийн олон бэрхшээлтэй тулгарсаар ирсэн бөгөөд одоо ч үргэлжилж байна. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш Монгол Улсад газрын харилцаатай холбогдолтой дараах тулгамдсан асуудлууд бий. Үүнд:

- Газрыг зах зээлийн эргэлтэд оруулах хууль, эрх зүйн орчин бүрдээгүйгээс газрын менежмент, газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээл төлөвшөөгүй,
- Иргэдэд газар өмчлөл, түүнтэй холбогдсон харилцааны талаарх ойлголт бага,
- Хот суурин бараадсан төвлөрлийг газар өмчлөлийн асуудалтай уялдуулж зохицуулаагүйн улмаас Улаанбаатар, Дархан, Эрдэнэт болон бусад төв суурин газруудад хэт төвлөрөл бий болж хурцадмал байдал үүсч дэд бүтцийн бодлогын хувьд оновчтой бус болсон,
- Газрын харилцааг зохицуулж шийдвэрлэх эрх мэдэл бүхий төрийн байгууллагуудын мэргэжлийн боловсон хүчнийг мэргэжил дээшлүүлэх болон давтан сургах явдал нэгдсэн стандартгүй, гадаадын улс орнуудын туршлагаас суралцах

талаар дутагдалтай, газрын алба ба газрын үнэлгээний албаны үүрэг функц тодорхой биш, удирдлага зохион байгуулалт сул, газрын үнэлгээгээр мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай, газрын зах зээлийн мэдээлэлд цогц дүн шинжилгээ хийгээгүй,

- Газар зүйн мэдээллийн системд суурилсан кадастрын нэгдсэн систем бий болоогүй, газрын зохион байгуулалт, газрын зөвшөөрөл, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн уялдаа холбоо муу байгаагаас газрыг үр ашигтай ашиглах явдал алдагдах сөрөг үр дагаврыг бий болгосон,
- Газрыг худалдах, худалдан авах, түрээслүүлэх, зээлийн барьцаа болгох талаарх гүйцэд мэдээлэл хүн амд хүрч чадаагүй,
- Үл хөдлөх хөрөнгийн татварын тогтолцоо сайн хөгжөөгүй
- Иргэдийг зээлийн бүртгэлд оруулж, ипотекийн зээлийг хөгжүүлж чадаагүй байдлууд бодитой бэрхшээл болж байв.

Газрын зах зээлийн менежмент амжилттай хэрэгжихэд хуулийн хүрээнд бүх газар болон түүнтэй холбоотой нөөцийг зөвхөн арилжааны хэлбэрт оруулах биш, ямар төрлийн бараа болгохыг ойлгомжтойгоор тодорхойлох нь чухал байв. Тиймээс газрын алба нь газар болон олон нийтийн эзэмшлийн хөрөнгийг кадастрын нэгдсэн санд бүртгэн газар болон үл хөдлөх хөрөнгийг зөв удирдах нөхцлийг хангах шаардлагатай байлаа. Түүнчлэн 1990 оноос хойш Монгол Улсад газрын зах зээл жинхэнэ утгаар төлөвшөөгүй, ихэвчлэн үл хөдлөх хөрөнгө, газар дээр баригдсан байшин барилгын худалдаатай холбож үзсээр ирлээ. Өнөөгийн нөхцөлд Монголд газрын зах зээл гол төлөв хот суурин газар, ялангуяа Улаанбаатарт хөгжиж байна.³³ Улаанбаатар хот 470 мянган га нутаг дэвсгэртэй бөгөөд газар хувьчлал эхэлснээс хойш 2005 оны байдлаар нийслэлийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 50'240 иргэн ашиглаж, эзэмшиж байгаа хашааныхаа 2'513 га газрыг, 1'260 иргэн 88,2 га газрыг шинээр тус тус өмчилж авчээ. Харин аймгуудын хэмжээнд гэр бүлийн зориулалтаар 44'363 иргэн одоо ашиглаж, эзэмшиж байгаа хашааныхаа 6'035,7 га газрыг, 17'670 иргэн 3'813,9 га газрыг шинээр,

³³ Төмөрхуяг, Б., “Нийслэл дэх газрын харилцаа ба газрын зах зээл”, Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг олон улсын бага хурал, Улаанбаатар, 2007.

41 иргэн аж ахуйн зориулалтаар 17,6 га газрыг тус тус өмчлөн аваад байв. Улсын хэмжээнд хоёр жилийн хугацаанд нийт 113`584 иргэн газар өмчлөн авчээ.³⁴ 2007 оны 9-р сарын 21-ний байдлаар нийслэлийн хэмжээнд Налайх болон Багануур дүүргийг оролцуулан нийтдээ есөн дүүргийн 63`960 өрх 3224,91 га газрыг өмчилж байгаа бөгөөд нийт өмчлүүлсэн газрын мөнгөн дүн нь 425`688 сая төгрөг болж байна.³⁵

Монгол Улсад газар хувьчлал хэдийнээ ийнхүү эхэлсэн ч хөдөө олж ахуйн газрын хувьчлах үнийг улсаас их өндөр тогтоож өгсний улмаас тариалангийн газрын бараг 60% нь ашиглагдалгүй үлдэж, нэг талаар хөрөнгө оруулалт хийх эзэнгүй нөгөө талаар орон нутгийн засаг захиргаа газраас авах татвар, түрээсээс олигтой орлого олж чадахгүй байв. Иймд газар ба үл хөдлөх хөрөнгийг жишээлбэл, зээлийн барьцаанд ашиглахуйц болгож үнэлэх шаардлагатай байна.

Энэхүү төслөөр газар болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, төсөл хэрэгжиж буй нутгуудад газрын менежментийг сайжруулахыг зорилгоо болгож байна. Төслийг Завхан, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт хэрэгжүүлэхээр сонгож аваад ажиллаж байна. Газар өмчлүүлэх үйл ажиллагаа явагдаж, үүнтэй холбоотойгоор орчин үеийн газрын менежментийн асуудал чухлаар тавигдаж байгаа бөгөөд газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах нь иргэдийн амжиргаанд төдийгүй, улсын эдийн засагт онцгой ач холбогдолтой байгаа билээ. Үүний тулд газрын менежментийн асуудлыг оновчтой шийдвэрлэх, тогтмол сайн ажиллагаатай кадастрын болон эрхийн бүртгэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санхүүгийн кадастрын буюу газрын үнэлгээний тогтолцоог шинээр бий болгох, газрын татвар, төлбөрийг ялгавартайгаар тогтоох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймээс төсөл дараах чиглэлүүдээр зөвлөх үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний орчин үеийн, ил тод аргачлалыг нэвтрүүлэх
- Төрийн өмчийн газрын менежментийн үр бүтээмжийг дээшлүүлэх

³⁴ Батсүх, Ш., Монгол Улсын газрын харилцааны шинэтгэлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, Улаанбаатар, 2007.

³⁵ Нийслэлийн газрын албаны Газар өмчлөлийн хэлтэс, Улаанбаатар, 2007.

- Ипотекийн зах зээлийг хөгжүүлэх
- Газрын эрх зүйн орчинг боловсронгуй болгож хөгжүүлэх
- Кадастрын тогтолцоог цаг тухайд нь сүүлийн үеийн мэдээгээр хангаж шинэчлэх
- Мэргэжлийн байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх болон олон нийтийг мэдээллээр хангах.

Төсөл нь юуны өмнө үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний олон улсын стандартын тухай мэдээллийг Монголын мэргэжлийн хүмүүст хүргэхэд анхаарлаа хандуулсан. Уг төсөл нь ХБНГУ-ын Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний системтэй танилцах аяллыг 3 дахь удаагаа зохион байгуулсан бөгөөд үүнд УИХ-ын гишүүд, сайд нар, агентлаг, газрын дарга нар, орон нутгийн газрын албаны удирдлага, мэргэжилтнүүд, энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулийн багш нар хамрагдаж, төрийн байгууллага, хувийн секторын ажил үүргийн хуваарь, уялдаа холбоотой танилцсан байна. Мөн төслийн зүгээс хамтрагч байгууллага болон их сургуулиудтай хамтран газар зохион байгуулалт, кадастр, газрын менежментийн чиглэлээр оюутан бэлтгэж буй зарим их сургуулиудын сургалтын хөтөлбөрийг жигдэлж чаджээ. Төслийн хүрээнд жил бүр 2-3 долоо хоногийн зуны сургалтыг түнш байгууллага болон их сургуулиудтай хамтран зохион байгуулж, газрын үнэлгээ, газрын менежмент, кадастрын үйл ажиллагаа, газарзүйн мэдээллийн систем, газар ашиглалтын төлөвлөлт гэх мэт чиглэлээр сургалтуудыг зохион байгуулсаар байна. 2007 оны зуны сургалтыг "Аж ахуйн зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, газрын харилцаа ба орон зайн мэдээллийн дэд бүтэц" сэдвээр зохион байгуулж, тухайн салбарын сүүлийн үеийн мэдээллээр оролцогчдод мэдээлэл хүргэлээ.

Мөн Үл хөдлөх хөрөнгө (ҮХХ)-ийн үнэлгээ, кадастрын хуулийн төсөл боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх, арилжааны буюу зах зээлийн үнийн мэдээлэлд тулгуурлан газрын жишиг үнэ тогтоох, түүнийг жил бүр шинэчлэн тогтоож, газрын үнэлгээний жишиг үнийн карт бэлтгэх, үүнд шаардагдах ҮҮХ-ийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах ажлыг хийж байна. Одоогоор ХБНГУ-ын Барьцааны үнэт цаасны тухай хуулийг монгол хэлнээ хөрвүүлэн, англи, герман, монгол 3 хэлээр товхимол болгон хэвлүүлсэн. Энэ хуультай холбогдуулан үл хөдлөх хөрөнгийн барьцааны үнэт цаасны тухай

олон нийтэд зориулсан гарын авлага бэлтгэн гаргалаа. Газрын хууль тогтоомжийн эмхтгэл хэвлүүлэх ажлыг санхүүжүүлсэн ба мөн Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны төслөөс хийгдэж буй кадастрын мэдээллийн өнцгө цаашид шинэчлэх нөхцлийг хангах үүднээс тус төслийн зүгээс өндөр нарийвчлал бүхий GPS-ын тоног төхөөрөмжийг Дархан-Уул аймагт нийлүүлээд байна.³⁶

8. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл

1998 оны 10-р сараас 2007 оны 3-р сар хүртэл Гадаадын иргэнгэ оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА), Үйлдвэр худалдааны Яамтай хамтран сонгож авсан 6 салбарын (мод боловсруулалт, барилга, арьс шир, хэвлэл, ноос боловсруулалт, аялал жуулчлал) төлөөлөл болох Ой мод эрдэм судлалын төв, Дунд бүтцийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институт, АРМОНО корпораци, ШУТИС-ийн дэргэдэх Хэвлэлийн үйлдвэр, сургалтын төв, ШУТИС-ийн харьяа Нэхмэлийн хүрээлэн, Аялал жуулчлал, удирдлагын дээд сургууль гэсэн 6 түнш байгууллага дээр 5,69 сая еврогийн өртөгтэй³⁷ хэрэгжүүлсэн төсөл юм.

Тухайн үед Монголын жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-үүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн олон улсын стандартын шаардлага хангахгүй, өрсөлдөх чадваргүй байх явдал нэлээд байсны зэрэгцээ тэд орчин үеийн эдийн засгийн механизм, технологи, зах зээлийн талаар мэдээлэл хомс, туршлага бага тул энэхүү төслийн хүрээнд сонгож авсан 6 салбарт ЖДҮ-үүдийн ажиллах болон өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд сонгож авсан 6 түнш байгууллагаараа дамжуулан ЖДҮ-үүдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахыг зорьсон билээ. Үүний дагуу хийгдсэн ажлуудыг дурдвал:

³⁶ Die GTZ in der Mongolei, Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne, Landmanagement-Fiskalkataster in der Mongolei, GTZ GmbH, Ulaanbaatar, 2006, S.13-14; Хөхтөмөр, Э., "GTZ газрын менежмент, санхүүгийн кадастрын асуудалд анхаарал хандуулж байна", Өнөөдөр, 2007.06.22. №146(3104); Хөхтөмөр Э., "GTZ-ийн зуны сургалт өндөрлөлөө", Өнөөдөр, 2007.09.05. №146(3104); ГТХАН-ийн Монгол Улс дахь гөлөөлөгчийн газрын материал, Улаанбаатар, 2008.

³⁷ Projektliste Mongolei, im Stand August 2005, BMZ.

1. Төслийн хүрээнд түнш байгууллагуудыг салбарын ЖДҮ-үүдэд үйлчилгээ үзүүлэх чадвар, чадавхтай болгож бэлтгэсэн. Энэ ажлын хүрээнд CIM, DED, SES-ийн олон улсын урт, богино хугацааны мэргэжилтэн нар түнш байгууллагад мэргэжлийн зөвлөгөөг өгсний зэрэгцээ гадаадынижилчиглэлийн мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоон хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлсэн байна. Жишээлбэл, аж үйлдвэрийн 24 зөвлөх, богино хугацааны 41 гадаад мэргэжилтэн төсөл эхэлснээс хойш төслийн шугамаар Монгол Улсад уригдан ирж, түнш байгууллагуудад зөвлөгөө өгч, сургалт явуулсан байна.³⁸ Төслийн түнш байгууллага болох АРМОНО корпорац 1999 оноос хойш ХБНГУ-ын Ройтлинген хотын савхины хүрээлэнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж байв. Мөн төслийн хүрээнд 500.000 еврогийн үнэ бүхий хэвлэлийн тоног төхөөрөмжийг ШУТИС-ийн дэргэдэх Хэвлэлийн үйлдвэр, сургалтын төвд ХБНГУ-ын Хайделбергийн хэвлэлийн институтээс авч өгөхөд дэмжлэг үзүүлсэн байна. 250.000 еврогийн үнэ бүхий мод боловсруулах тоног төхөөрөмж бүхий Мод боловсруулах сургалтын төвийг Ой мод эрдэм судлалын төвийн дэргэд байгуулахад төслийн зүгээс дэмжлэг үзүүлсэн ажээ.³⁹ Бэлтгэгдсэн түнш байгууллагууд цаашид ЖДҮ-үүдэд дараах үйлчилгээг үзүүлэх болжээ. Үүнд:

- 170 гаруй ЖДҮ-тэй байнгын холбоо тогтоож, тэдний эн тэргүүний шийдвэрлэх бэрхшээл, тусгай эрэлт, хэрэгцээ зэргийг судалсны үндсэн дээр ямар үйлчилгээ авах хүсэлтэй байгааг тодорхойлсон.⁴⁰
- Салбарын мэргэжлийн сэтгүүл, хэвлэл, зөвлөмж, лавлах материал, тодорхой сэдвээр танилцуулга зэргийг бэлтгэж интернэтээр дамжуулж илгээдэг байна. Байнгын холбоотой ажиллаж байсан ЖДҮ-үүдийн ихэнх нь мэдээлэл, документац, сургалт, зөвлөгөө, маркетингийн үйлчилгээний хөтөлбөрт төлбөртэй үйлчлүүлсэн байна.⁴¹

³⁸ Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төслийн танилцуулга, ГТХАН, Улаанбаатар, 2004.

³⁹ Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төслийн танилцуулга, ГТХАН, Улаанбаатар, 2004.

⁴⁰ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Förderung von Klein- und Mittelunternehmen, GTZ.-Office Ulaanbaatar, S.12.

⁴¹ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Förderung von Klein- und Mittelunternehmen, GTZ.-Office Ulaanbaatar, S.12.

- Үйлчилгээний хөтөлбөр: Тухайн ЖДҮ-т тулгамдсан асуудлаар ганцаарчилсан зөвлөгөө өгөх, тодорхой сэдвээр практик сургалт явуулах болон бусад үйлчилгээ орно. Санхүүгийн боломжийн улмаас ЖДҮ-үүд зөвлөгөө авах нь хязгаарлагдмал байсан тул практик сургалтыг явуулах нь эдийн засгийн хувьд илүү үр ашигтай байжээ. Төслийн түнш байгууллагуудын зохион байгуулсан төрөл бүрийн сургалтанд нийт 500 гаруй ЖДҮ хамрагджээ. Мөн олон улсын 16 үзэсгэлэн худалдаанд ЖДҮ болон түнш байгууллагууд оролцсон байна.⁴² Үүнээс хамгийн том нь 2000 оны 3-р сард Берлины Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт Монголын аялал жуулчлалын 14 компанийг оролцуулсан явдал байлаа.⁴³

Энэ төсөл хэдийгээр 2006 оны сүүлчээр дууссан ч төслийн түнш байгууллагууд болон сургалтын төвүүд замхран ууссангүй, харин ч үйл ажиллагаа нь өргөжин тэлсэн байна. 2007 оны байдлаар ШУТИС-ийн дэргэдэх Хэвлэлийн үйлдвэр, сургалтын төв нь Улаанбаатар хотод 90 гаруй, хөдөө орон нутагт 40 орчим ЖДҮ-тэй холбоо тогтоон хамтран ажиллаж буй ажээ. Мөн Дэд бүтцийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институтэд төслийн хүрээнд байгуулагдсан Барилгын сургалтын төв нь Улаанбаатар хотод 90 гаруй, хөдөө орон нутагт 35 гаруй байгууллагатай хамтран ажиллаж, 12 төрлийн багц сургалтанд нийт 209 аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг хамруулаад байв.⁴⁴

9. Мал эмнэлгийн хувьчлалыг дэмжих төсөл

Төслийн эхний үе шат

1999 оны 5-р сараас 2005 оны 12-р сар хүртэл төслийн эхний үе шатыг Монгол Улсын ХААҮЯ, ХХААЯ-тай хамтран Төв, Дорноговь, Завхан, Увс аймагт 3,32 сая еврогийн өртөгтэй⁴⁵ хэрэгжүүлсэн.

⁴² Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төслийн танилцуулга, ГТХАН, Улаанбаатар, 2004.

⁴³ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Förderung von Klein- und Mittelunternehmen, GTZ.-Office Ulaanbaatar, S. 9-12.

⁴⁴ Хөхтөмөр, Э., ЖДҮ-ийг дэмжих төслийн тухай тэмдэглэл, Улаанбаатар, 2007

⁴⁵ Projektliste Mongolei, im Stand August 2005, BMZ.

Монголд төрийн мэдэлд байсан мал эмнэлгийн албадын хувьчлал 1999 онд явагдаж дууссан ч хувийн мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байлаа Малаас хүнд халдварлах өвчнүүдийг оношлох, тандах шинжилгээг хангалттай хийж чадахгүй байгаагаас өвчлөлийг бүрэн хянаж чадахгүй байв.

Социалист нийгмийн жилүүдэд улсын хэмжээнд малын халдварт өвчинтэй тэмцэх, эрүүлжүүлэх ажлыг 1958-1960, 1962-1965, 1968-1980, 1981-1987 онд 4 үе шаттайгаар явуулснаар малын зарим халдварт өвчний гаралтыг бууруулж, нэлээд амжилт олж байсан боловч эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлж, мал сүргийг хувьчилснаар улсаас хэрэгжүүлэх мал эмнэлгийн бодлогод ч өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлага зүй ёсоор тавигдсан билээ 1987-2003 он хүртэлх 15 жилийн хугацаанд мал сүрэгт халдварт өвчнийг тандан судлах шинжилгээ хийгээгүйгээс өвчний халдварлалт, тархалтын байдал тодорхой биш болсон байв.

Малын халдварт өвчний гаралт, тархалт нэмэгдэх нь хүн амын эрүүл мэнд, улсын эдийн засагт хохирол учруулж, хүнсний аюулгүй байдал, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортод сөргөөр нөлөөлсөөр иржээ. Иймээс мал эмнэлгийн ялангуяа хувийн мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, мэргэжилтэй боловсон хүчнийг чадваржуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах шаардлага амьдралаас зүй ёсоор урган гарсан юм.

Тус төслийн зорилго нь Монголд зах зээлийн эдийн засгийн нөхцөлд тохирсон, малчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн мал эмнэлгийн үйлчилгээний тогтолцоог малчид, малын эмч нарын хамтаар бий болгох явдал юм. Чингэхийн тулд мал эмнэлгийн үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэхэд оролцож буй малчид, малын эмч нар, шийдвэр гаргагч гэсэн микро, мезо, макро төвшний оролцогчдыг хооронд нь уялдуулан холбосноор иж бүрэн тогтолцоог бүрдүүлж чадах ажээ. Үүний тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ доорх үе шатаар явагджээ.

1. Малын эмч нар болон шийдвэр гаргагч нарыг төсөл хэрэгжүүлэхэд зориулж бэлтгэх үе шат:

- Шийдвэр гаргагч нарыг төсөлд татан оролцуулахын тулд төслийн зохицуулах зөвлөл байгуулж, 2000 оны 3-р сард үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байна.

- Монголын мал эмнэлгийн Холбоо (МонМЭХ)-г бэхжүүлж, малын эмч нарт сургалт явуулах чадварыг дэмжсэн. Тухайлбал, МонМЭХ-ны удирдах хүмүүсийг ХБНГУ-д туршлага судлуулахаар явуулж, Баварийн мал эмч нарын танхимтай шууд харилцаа тогтооход дэмжлэг үзүүлсэн. МонМЭХ-ноос малын эмч нарт мэргэжил дээшлүүлэх, хувийн мал эмнэлгийн эдийн засгийн талаар сургалт явуулах боломжтой болгохын тулд сургагч нарыг бэлтгэж сургасан.
 - Хөдөөгийн хувийн малын эмч нар эм, багаж хэрэгслийн хангамж, санхүүжилтийн асуудлаа шийдвэрлэхэд малын эмч нар хамтран хангамжийн хоршоо байгуулах нь ашигтай болохыг малын эмч нарын дунд сурталчилж, тэднийг хоршооны сургалтанд хамруулсны үр дүнд малын эмч нарын 5 хоршоо байгуулагдаж, нийт 92 эмчийг эгнээндээ нэгтгэсэн байна. Тэдгээр хоршоонд эхний 3 сарын хугацаанд хэрэглэх зайлшгүй эм тариа, хэрэгслийг бэлтгэж өгсөн бөгөөд тэд энэ эм тариагаа зарж бий болгосон фондоороо дараа дараагийн саруудад хэрэглэх эм тариагаа худалдан авах замаар өөрөө өөрийгөө санхүүжүүлж эхэлжээ. Төсөл хэрэгжиж буй газруудад төдөлгүй малын эм тарианы гүйлгээ, мал эмнэлгийн үйлчилгээ эрс нэмэгдэх болсон байна.
2. Тухайн сонгож авсан газруудад төслийн хүрээнд шинэ загварыг туршин хэрэгжүүлэхэд шаардагдах таатай нөхцлийг бүрдүүлэх үе шат:
- Нутаг орондоо нэр хүндтэй малчныг сонгон авч, малчдад зөвлөгөө өгөх арга зүйд сургаж, тодорхой сэдвүүд дээр дадлага хийлгэсний дараа тухайн сэдвээр нь зөвлөгөө өгүүлэх, ажлынх нь явцад тусгайлан бэлтгэгдсэн зааварлагч чанарын хяналт тавих, дэмжиж туслах ажлыг гүйцэтгүүлсэн байна.
3. Төслийн амжилттай хэрэгжүүлж буй загваруудыг боловсронгуй болгох, түгээн дэлгэрүүлэхийн тулд бусад аймаг, сумуудтай мал эмнэлгийн асуудлаар харилцан туршлага солилцох, танилцуулах замаар дэмжлэг үзүүлэх үе шат:

- Удирдах албан тушаалын түншлэгч мэргэжлийн хүмүүсийг 14 хоногийн хугацаагаар ХБНГУ-д явуулж, мэдээлэл, сургалтанд хамруулсан. Мал эмнэлгийн хувьчлалын асуудлаар мэдээлэл солилцох хамтарсан уулзалт, арга хэмжээг АНУ-ын тусламжийн Говийн санаачилга, ACDF-VOCA, АХБ, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан.⁴⁶

Төслийн сүүлчийн үе шат

2006 оны 1-р сараас 2008 оны 6-р сар хүртэл ХБНГУ-ын болон Нидерландын хосолмол санхүүжилтээр хэрэгжиж буй бөгөөд 2,45 сая еврогийн өртөгтэй юм. Төслийн энэхүү сүүлчийн шатыг Нидерландын Засгийн газрын дэмжлэгтэйгээр байгаль орчныг хамгаалах чиглэлээр төсөл хэрэгжиж буй Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгийн нэр бүхий сумдад хэрэгжүүлж байна. Энэ үе шатанд уг төслийг “Хувийн малын эмнэлгийн албадад дэмжлэг үзүүлэх төсөл” хэмээн нэрлэдэг бололтой.

Төслийн төгсгөлийн шатны хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудыг дурдвал:

Төслийн зүгээс малын эмч нарт хувийн эмнэлгээ удирдах хөтлөхөд нь зөвлөгөө өгсөн. Малчдад малын эрүүл ахуйн асуудлаар зөвлөгөө өгөх асуудлаар Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвд дэмжлэг үзүүлсэн. Монголын Малын эмч нарын холбоог малын эмч нарт мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллага болгон төлөвшүүлсэн. Улсын мал эмнэлгийн албадад зохих эрх зүйн үндсэн орчин нөхцлийг бүрдүүлэхэд зөвлөгөө өгсөн. Эдгээр оролцогч нарт мэдлэг, чадвараа сайжруулах, түншийн холбоо тогтоох зэрэг асуудалд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлжээ.

Төслийн үр дүнд мал эмнэлгийн үйлчилгээний тохиромжтой загварыг хамтран бий болгож чадсан нь цаашдаа Монголын мал аж ахуйн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар нэмэгдэхэд ач холбогдолтой болжээ.⁴⁷

⁴⁶ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001. Unterstützung der Privatisierung von Veterinärdienstleistungen, GTZ.-Office Ulaanbaatar, S. 41-44

⁴⁷ Die GTZ in der Mongolei, Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne, Förderung privatwirtschaftlicher Veterinärdienste, GTZ GmbH, Ulaanbaatar, 2006, S.29-30; ИТХАН-ийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын материал, Улаанбаатар, 2008.

10. Олон улсын худалдааны бодлогын салбарт хамтран ажиллах төсөл

1999 оны 8-р сараас 2003 оны 12-р сар хүртэл Монгол Улсын ҮХЯ дээр 1,53 сая еврогийн өртөгтэй⁴⁸ хэрэгжсэн төсөл юм.

Шилжилт хийж буй хуучин социалист орнуудаас анх удаа Монгол Улс 1997 онд ДХБ-д элсэж, олон улсын худалдаанд нээлттэй оролцох болжээ. Үүний үр дүнд Монголын эдийн засгийн хөгжилд боломжууд нээгдсэн боловч үндэстний бие даан шийдвэр гаргах нөхцөл хязгаарлагдаж эхэлсэн. Тухайн үед Монголын хөрш Хятад, Орос нь төдөлгүй ДХБ-д элсэх гэж байсан нь эдийн засгийн үндсэн нөхцлүүдийг гүнзгий өөрчлөхөд хүргэхээр байлаа. Энэ өөрчлөлтийг Монгол Улс амжилттайгаар зохион байгуулахад уян хатан холбон түүчлах механизм, худалдааны бодлогын холбогдолтой үндсэн чухал мэдээлэл ба түүний үндсэн дээр бий болох стратеги дутагдаж байлаа. Иймд энэ төслийн хүрээнд үндэсний хэмжээний худалдааны бодлого боловсруулах, үндэсний хүчин чадлыг нэмэгдүүлэх, эрх зүйн үндсэн нөхцлүүдээ сайжруулахад Монголын Засгийн газарт дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

Үүний дагуу хийгдэж буй ажлуудыг дурдвал:

- Үндэсний хэмжээний худалдааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх:

Эхний алхам болгож ҮХЯ дээр Үндэсний Зөвлөмж, мэдээллийн төвийг байгуулсан бөгөөд уг төв нь худалдааны бодлогын холбогдолтой чухал мэдээллүүдийг хэвлэмэл ба электрон бичмэл хэлбэрээр Монголын энэ чиглэлийн бусад яамд, Засгийн газрын агентлагууд болон бусад хувийн хэвшлийн эдийн засгийн байгууллагуудад бэлтгэж өгчээ. ҮХЯ нь энэ мэдээллийн баазыг уг төслийн тусламжтайгаар Монголын гадаад худалдааны тэргүүлэх салбаруудад тодорхой зорилготойгоор хийсэн анализ судалгаагаар баяжуулж, улмаар энэ бааздаа тулгуурлан чиглэлийн бусад яамд, агентлагуудтай хамтран стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг зохиох ажээ.

⁴⁸ Projektliste Mongolei, im Stand August 2005. BMZ.

- Үндэсний хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх:

ҮХЯ болон нэг чиглэлийн бусад яамд, агентлагуудын холбогдох газрын мэргэжилтэн нарыг 3 сар хүртэлх хугацаагаар Женевын Олон Улсын Байгууллага дахь Монголын байнгын төлөөлөгчийн газарт дадлага хийлгүүлсэн нь тэдэнд мэргэжил мэдлэгээ дээшлүүлэхийн хамт худалдааны бодлогын чухал салбаруудад холбоо тогтоох боломж олгосон юм. Мөн Монголын засаг захиргаа, эдийн засгийн хүрээний дотор худалдааны бодлогод нөлөө бүхий оролцогч нарт зориулж тодорхой сэдвээр сургалт зохион байгуулахын зэрэгцээ худалдааны бодлогын асуудлаар мэдээллийн чанартай материалуудыг монгол хэлээр хэвлэн гаргасан байна.

- Эрх зүйн үндсэн нөхцлүүдээ сайжруулахад Монголын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх:

Гадаад худалдааны эрх зүйн үндсэн нөхцлийг сайжруулахын тулд холбогдох хууль тогтоомжийн төсөлд зөвлөгөө өгөх замаар дэмжлэг үзүүлэх ажээ.⁴⁹

11. Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого төсөл

2004 оны 1-р сараас 2007 оны 12-р сар хүртэл Монгол Улсын ҮХЯ дээр 2,15 сая еврогийн өртөгтэй⁵⁰ хэрэгжижбуй төсөл. Энэ төсөл нь үндсэндээ "Олон улсын худалдааны бодлогын салбарт хамтран ажиллах төсөл"-ийн үргэлжлэл төсөл юм.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих энэхүү хугацаанд бүтэц, зохион байгуулалтын ихээхэн өөрчлөлт хийж, эдийн засгаа тогтворжуулж, эдийн засгийн тодорхой өсөлтийг бий болгож чадсан хэдий ч Монгол Улсын дотоодын зах зээл нь ядуурал, ажилгүйдлийн түвшинг дорвитой бууруулахад хангалттай нөлөөлөхүйц тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгоход хэт жижиг байна. Өнөөгийн экспортын хүчин чадлыг шаардлагатай хэмжээгээр ашиглахад Монгол Улсын экспортын барааны өрсөлдөх чадварын сул дорой

⁴⁹ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Zusammenarbeit auf dem Gebiet der Internationalen Handelspolitik/WTO, GTZ.-Office Ulaanbaatar, S. 17-18.

⁵⁰ Die GTZ in der Mongolei, Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne. Exportorientierte Industrie- und Handelspolitik, GTZ GmbH, Ulaanbaatar, 2006, S.11-12.

байдал, гадаадын зах зээлд хүрэх экспортын боломж хязгаарлагдмал, мангуяа экспортыг дэмжих төрийн бодлого дутагдалтай, экспортын зохиоёрөл олгох журам хүнд суртал ихтэй, гаалийн болон импортын татвар өндөр, гаалийн бүрдүүлэлт хийх явц удаан зэрэг хүчин зүйлс саад тотгор учруулж байна. Иймд, үндэсний үйлдвэрлэл, худалдааны бодлогыг хооронд нь уялдуулан зохицуулах шаардлага байсаар байна.

Үүнтэй холбоотойгоор энэхүү төслөөр Монголын аж ахуйн нэгжүүдийн гадаад зах зээлд гарах гарцыг бүтцийн хувьд сайжруулахыг зорих бөгөөд чингэхдээ Монголын аж ахуйн нэгжүүд өөрсдийн экспортоо нэмэгдүүлэхэд нь тэдэнд шууд дэмжлэг туслалцаа үзүүлж, өөшлөгөө өгөхөд чиглэх бус харин Монголд экспортын баримжаатай бизнесийн салбарт эрх зүйн бүтцийн таатай орчинг бүрдүүлэхэд гол анхаарлаа хандуулах ажээ. Тодруулбал, төслийн хүрээнд дараах чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх ажээ. Үүнд:

- Тодорхой салбар, бүтээгдэхүүний экспортын стратеги бодлого боловсруулах,
- Үйлдвэр, худалдааны бодлогын уялдаа холбоог сайжруулах,
- Экспортын баримжаатай компаниудын үйл ажиллагаа явуулах бизнесийн орчны эрх зүй, зохион байгуулалтын бүтцийг сайжруулах,
- Экспортын салбарын асуудлаар төр-хувийн хэвшлийн хооронд бодлогын чанартай харилцан санал солилцох ярилцлагыг тогтмол зохион байгуулах зэрэг орж болно.⁵¹

Төслийн үр дүнг Монголын экспортын болон хөрөнгө оруулалтын үндсэн таатай орчин, нөхцөл хэр бүрдэв, нийт ЖДҮ-үүдийн дунд чанарын менежментийн стандартыг хангасан экспортын чиглэлийн аж ахуйн нэгжүүдийн эзлэх хувь хэр их нэмэгдэв гэдгээр хэмжих ажээ. 2004 онд санал асуулгад оролцсон компаниудын 25% нь экспортын дотоод орчин нөхцөл, гадаадын зах зээлд гарах гарц, хөрөнгө оруулалтын дотоод орчин Монголд сайжирсан гэж хариулсан бол 2005 онд энэ тоо 30%-д хүрсэн байна.⁵²

⁵¹ Төслийн тухай, Төслийн танилцуулга, Зөвлөгөө өгөх чиглэл, <http://www.trade-policy.mn/mon/mine/project-description.php>

⁵² Die GTZ in der Mongolei, Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne, Exportorientierte Industrie- und Handelspolitik, GTZ GmbH, Ulaanbaatar, 2006, S. 11-12.

12. Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр

2006 оны 6-р сараас 2010 оны 6-р сар хүртэл Монгол Улсын Сангийн яам, Дархан-Уул, Орхон, Завхан аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран хэрэгжүүлж буй 10,116 сая еврогийн өртэгтэй⁵³ төсөл юм.

Монгол Улсад шилжилтийн эхэн үед хөдөө орон нутагт боловсруулах үйлдвэр, олон нийтийн болон нийгэмд үйлчилдэг олон байгууллагууд үүдээ барьснаар ажилгүйдэл хавтгайрсан байв. Хөдөө орон нутагт компаниуд байгуулагдаж эхэлсэн боловч тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сул, компанийн удирдлагад менежментийн мэдлэг дутмаг, компанийн хувьд санхүүгийн үйлчилгээ авах боломж хомс байлаа. Энэ байдлаас гарах гарц нь бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд шаардагдах урьдач нөхцлүүдийг хангах явдал байсан юм. Монгол Улсын Засгийн газар бүс нутгийн хөгжлийг дэмжихийн тулд 4 бүс нутагт хувааж, анхны алхмуудыг хийж буй ч бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих үзэл баримтлал, аргачлал нь бүрэн төлөвшөөгүй, боловсон хүчний мэдлэг чадвар хангалттай бус зэрэг бэрхшээлүүд оршсоор байлаа.⁵⁴

Иймд тус төсөл нь сонгож авсан бүс нутагт орон нутгийнх нь нөөц бололцоог тогтвортой ашиглах замаар бүс нутгийн эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх нөхцөл бололцоог нэмэгдүүлэх явдлыг зорилгоо болгожээ. Тус зорилгод хүрэх арга зам нь дараах бүрдэл хэсгүүдтэй. Үүнд:

- Сонгож авсан бүс нутагт бичил, жижиг, дунд үйлдвэр, хоршоодыг дэмжих: Үүнд орон нутгийн жижиг бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг дэмжих, тэдэнд зориулсан мэдээлэл, сургалт, зөвлөх үйл ажиллагааг сайжруулах, тодорхой салбарын ажилчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр багагүй ажил хийжээ. Тухайлбал, Германы хөгжлийн албаны 2 мэргэжилтэн Дархан, Улиастай хотын Мэргэжил, сургалт, үйлдвэрийн төвүүдэд ажиллаж, бүс

⁵³ Die GTZ in der Mongolei, Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne, Programm Regionale Wirtschaftsförderung, GTZ GmbH, Ulaanbaatar, 2006, S.23-24.

⁵⁴ Die GTZ in der Mongolei, Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne, Programm Regionale Wirtschaftsförderung, GTZ GmbH, Ulaanbaatar, 2006, S.23-24.

нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэрт хэрэгцээ шаардлагатай байгаа мэргэжлийн сургалтыг өргөжүүлэх зорилгоор барилгын мэргэжил эзэмшүүлэх сургалтанд зөвлөгөө өгч байна.

- Бүс нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, хоршоодод үзүүлэх санхүүгийн үйлчилгээг сайжруулах:
- Үүнд, санхүүгийн байгууллагуудын боловсон хүчнийг мэргэшүүлж, зээлийн баталгааны сан байгуулсан. 2007 онд Зээлийн баталгааны санг ашиглах хамтын ажиллагааны гэрээнд ГТХАН, “Зоос”, “Монгол шуудан”, “ХААН”, “Хас”, Худалдаа, хөгжлийн банк гарын үсэг зурснаар төсөл хэрэгжиж буй Дархан-Уул, Орхон, Завханы гурван бүсийн үйлдвэрлэл эрхлэгчид банкнаас зээл авахад барьцаа хөрөнгө хүрээгүй тохиолдолд бизнес төлөвлөгөөгөө сайтар боловсруулсны дараа Зээлийн баталгааны сангаас тусламж авах боломжтой болсон. Зээлийн баталгааны сан нь нэг аж ахуйн нэгжид зээл авахад нь 30 хүртэл сая төгрөгийг 6-24 сарын хугацаагаар, эрсдэлийн 50 хувьд баталгаа гаргаж өгөх юм. Тус төслөөс зарласан “Бизнес төлөвлөгөө 2007/2008-Монгол” уралдааны ялагч 18 хүн 1,5-0,75 сая төгрөгийн мөнгөн урамшуулал хүртэж, бүсийн болон үндэсний зөвлөхүүдийн үйлчилгээг үнэгүй хүртэх эрхээр шагнуулж, ГТХАН-ийн зээлийн баталгааны сангийн дэмжлэгтэйгээр түнш банкуудын зээлд хамрагдах боломжтой болсон байна.
- Тухайн бүсийн эдийн засгийн бодлогыг боловсронгуй болгох:
- Үүнд, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг сайжруулж, орон нутгийн болон үндэсний хэмжээнд шийдвэр гаргагчдын хэлэлцэж буй асуудлыг бүс нутгийн эдийн засгийн бодлого зорилготой уялдуулж, бүтэц, зохион байгуулалтын орчныг сайжруулах чиглэлээр олон ажил хийгдэж байна.⁵⁵

⁵⁵ Хөхтөмөр, Э., “GTZ орон нутгийн бизнес эрхлэгчдэд зээлийн баталгаа өгнө”, Өнөөдөр, №134(3092), ВЗ; ГТХАН-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын материал, Улаанбаатар, 2008.

13. Хотын хөгжил, барилгын салбар болон мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих хөтөлбөр

“Хотын хөгжил, барилгын салбар болон мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих” хөтөлбөрийг Монгол Улсын Барилга, Хот Байгуулалтын Яам, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам болон Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран 2006 оны 6-р сараас эхлэн дөрвөн жилийн хугацаатай (эхний үе шат бөгөөд 4.5 еврогийн санхүүжилттэй хөтөлбөр) хэрэгжүүлж байгаа бөгөөд хот байгуулалтын цогц төлөвлөлт хийх, салбарын хүрээнд баримтлах бодлого, стратеги боловсруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, барилгын салбар болон мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор хэрэгжиж байна.

Тус хөтөлбөр нь Мянганы Хөгжлийн Зорилтын (МХЗ) хүрээнд үндсэн дэд бүтцийг бий болгох, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, зардал багатай орон сууцаар хангах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, тэр дундаа орлого багатай иргэдэд зориулсан ажлын байрны сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар ядуурлыг бууруулахад өөрийн хувь нэмрээ орууна.

Монгол Улсад хотжилтын түвшин 57%-тай байгаа ба төвлөрөлт нь үндсэндээ нийслэл хотдоо явагдаж байгаа тул ядуу болон ажилгүй хүмүүсийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Хотжилт болон эдийн засгийн өсөлт ихэнхдээ нийслэлд явагдаж байгаагаас хот руу нүүн суурьших явдал үргэлжилж, хотын дэд бүтцийн хангамж, хүртээмж жилээс жилд дордож байна. Нөгөө талаар энэ бүгдийг шийдвэрлэхэд нэгдүгээрт, хотын удирдлага менежмент сул, хот байгуулалт, төлөвлөлт дутмаг байгаагаас тав тухтай амьдрах нөхцлийг хангахааргүй дэд бүтэц муутай гэр хороолол улам ихээр тэлж байна, хоёрдугаарт, бага болон дунд орлоготой иргэдэд зориулсан өртөг зардал багатай, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц хүрэлцээгүй болж, гуравдугаарт, одоо байгаа хуучин орон сууцнууд нь элэгдэн муудаж шаардлага хангахааргүй болж байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт системээс үүдэлтэй эрх үүргийн тодорхой бус байдал, одоогийн мөрдөгдөж байгаа норм, стандарт ба тарифын хоцрогдол, хот байгуулалт, төлөвлөлтийн чадавхи,

Барилгын ажлын гүйцэтгэлийн болон чанарын хяналт, дадлагад тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалт, барилгын салбарт нэвтрүүлж буй орчин үеийн техник, технологи, мэргэжлийн ур чадвар дутмаг байгаагаас зөв зохистой шийдэл гаргахад Монголын талд үндрэл учирч байна.

Энэ бүгдийг үндэс болгон хөтөлбөр нь Монголын талын түнш байгууллагуудтай хамтран дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

Хөтөлбөр нь 4 бүрэлдэхүүн хэсэгтэй:

1. Зардал багатай, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц
2. Эрчим хүчний хэмнэлттэй, зардал багатай орон сууцны барилгын засварлалт
3. Оршин суугчдын оролцоонд тулгуурласан төвлөрсөн бус, байгаль орчинд халгүй гэр хорооллыг хөгжүүлэх стратеги
4. Эрэлтэд нийцсэн мэргэжлийн боловсрол, сургалт

Зардал багатай, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц төсөл

Баянгол дүүрэгт баригдах эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны барилга

Баянгол дүүрэгт олгогдсон газарт (400 м²) эрчим хүчний хэмнэлттэй 40 айлын орон сууцны барилгын зураг төслийг бэлэн болгож БХБЯ-нд хүлээлгэн өгөхөд бэлэн болсон. Санхүүжилтийг шийдвэрлэсэн нөхцөлд 2008 онд барилгын ажлыг эхлүүлэх бөгөөд тус хөтөлбөр нь барилгын гүйцэтгэл болон чанарт хяналт тавих болно. Боловсруулсан зургийн дагуу одоо байгаа гадна дулааны шугамыг шилжүүлэх ажил хийгдсэн.

Монгол Германы Эко-хотхон, Нисэх

Нисэхийн орчимд олгогдсон 72.5 га газарт Монгол-Германы ЭКО-хотхоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж байна. Ингэхдээ эрчим хүчний хэмнэлттэй техник технологи, төвлөрсөн бус инженерийн хангамжийн шийдлийг (саарал усыг

эргүүлэн ашиглах, нарны энергийг дулаан гаргах зориулалтаар ашиглах г.м) нэвтрүүлэх болно.

Ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг профессор Круше, Германы Брунсвик хотын Техникийн Их сургууль, сууцны архитектур төлөвлөлтийг тус хөтөлбөр, барилгын хийц бүтээцийн хэсгийг профессор Шлайх, дэд бүтцийг INTERPLAN болон SAG компани Монголын зураг төслийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ.

Ерөнхий төлөвлөгөөний эхний төслийг 2007 оны 8-р сарын 8-нд БХБЯ, НЗДТГ, БХБНААҮТөв (Барилга, хот байгуулалт, нийтийн аж ажуйн Үндэсний төв) зэрэг байгууллагуудад танилцуулсан. Эхний ээлжийн барилгажилтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг (14.5 га) боловсруулж Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлтийн газраар батлуулсан бөгөөд эхний ээлжинд 71 айлын 2 давхар Townhouse маягийн 2-3 давхар эгнээ орон сууц баригдана. Сонирхож буй хүмүүст сууцны зураг төслийг танилцуулах ажил эхэлсэн.

Эрчим хүчний хэмнэлттэй, зардал багатай орон сууцны барилгын засварлалт төсөл

Баянбүрдийн угсармал сууцны засвар

Чингэлтэй дүүргийн, 5-р хороо, 29 айлын угсармал орон сууцны 8-р байранд дулаалга болон техникийн шинэчлэл бүхий засварыг хийж гүйцэтгэсэн. (Чингэлтэй дүүрэг, Баянбүрдийн орчим)

Засварын ажлын хүрээнд зоорийн давхрыг бүрэн засварласан, тухайлбал цэвэр бохир ус, дулааны инженерийн шугам сүлжээг шинэчилсэн, гадна фасад, балконыг дулаалсан, цонх болон орцны хаалгыг бүрэн сольсон, дээврийг шинэчилсэн. Зоорийн давхарт халаалтын автомат хаалт бүхий холигч узелийг шинээр суурилуулсан. Мөн хэмжилт, мониторинг хийх багаж хэрэгслийг суурилуулсан.

ХБНГУ-ын Фраунховерийн барилгын физикийн институт эрчим хүчний хэрэглээг хянах, үнэлж дүгнэх, мониторинг хийх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар ажиллаж байгаа бөгөөд 2008 оны нэгдүгээр улиралд хийсэн завсрын хэмжилтээр тухайн барилгад 40-50% хүртэл хувийн дулааны хэмнэлт гарах үр дүн гарсан.

Засварын ажил эрчим хүчний хэмнэлтээс гадна орон сууцанд амьдрах тав тухыг үлэмж хэмжээгээр сайжруулсан тул оршин суугчид сэтгэл хангалуун байгаа. Түүнчлэн зоорийн давхарт айл бүрт өөрсдийнх нь санхүүжилтээр "харанхуй өрөө" гаргаж өгсөн.

Монголын Сууц Өмчлөгчдийн Холбооны Дээд Зөвлөл (МСӨХДЗ)-тэй тухайн байгууллагын чадавхийг сайжруулах, СӨХ-ийн ажил үйлчилгээг боловсронгуй болгох, засвар үйлчилгээнийхэд шаардагдах төлбөрийг нэмэгдүүлэх, оршин суугчид, СӨХ-д, СӨХДЗ-ийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, тодорхой болгох талаар үүнзэлт, ярилцлагыг үргэлжлүүлэн хийж байгаа ба тэдний хүсэлтээр СӨХ-д зориулсан эрчим хүчний хэмнэлттэй засварын сургалтыг 4 сард зохион байгуулсан. Ингэснээр СӨХ-ын засварын ажлын чанар, гүйцэтгэлийг хянах чадавхийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр орууллаа. Цаашилбал, сууц өмчлөгчид болон СӨХ-ын эрх зүйн орчныг боловсронгуй болгох үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ.

Дулааны үнэ тарифыг зах зээлийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох чиглэлээр зарим ажлыг эхлүүлсэн. (тухайлбал, ТЭХЯам, Эрчим хүчний зохицуулах газартай хамтран хэрэглээнээс хамааралтай үнэ тарифыг нэвтрүүлэх, турших ажлыг загвар төслийн барилга дээр эхлүүлсэн, халаах хэрэгсэл дээр ууршигч тоолууруудыг суурилуулсан)

Энэ ажлын ач холбогдлыг бусад донор байгууллагууд өндрөөр үнэлсэн бөгөөд тухайлбал, АХБ болон Германы Сэргээн босголтын банк угсармал болон бусад хуучин орон сууцны барилгад цаашид хийгдэх дулаалга болон техникийн шинэчлэлд зориулж хөнгөлттэй тээл олгох боломжийг судалж байна. (Үнэ тарифыг нэмэгдүүлэх, хэрэглээнээс хамааралтай болгох нь доноруудын хувьд чухал бэйгаа)

Эрчим хүчний хэмнэлттэй болгох засварын ажлыг тогтвортой үргэлжлүүлэхийн тулд санхүүгийн механизмыг бий болгох нь чухал бөгөөд энэ талаар БХБЯ болон НЗДТГазартай хамтран ажиллаж байна.

Оршин суугчдын оролцоонд тулгуурласан төвлөрсөн бус, байгаль орчинд халгүй гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төсөл

ЭКОСАН хуурай бохирын систем

Энэхүү хуурай бохирын системийг турших ажлыг 2006-2008 оны өвлийн туршид гүйцэтгэсэн. ЭКОСАН-ны дизайныг сайжруулсан боловч, үнэ өртгийг бууруулах зорилгоор цаашид улам боловсронгуй болгох шаардлага байгаа.

Одоогийн байдлаар 20 гаруй ЭКОСАН бие засах газар ашиглагдаж байна. Үүнд, Эрдэнэт хотын гэр хороолол ("Арвин" хөршийн холбоо), өнчин хүүхдийн цэцэрлэг, залуучуудын зуслан, МСҮТөвүүд зэрэг газар орно. Мөн Зам, тээвэр, аялалын яам жуулчлал жуулчны баазад турших сонирхлоо илэрхийлсэн. Гэр хорооллын дундаж айл өрхөд ЭКОСАН нь өндөр үнэтэй хэвээр байна. Иймд түүнийг хямдруулах боломжийг судалж байгаа бөгөөд тухайлбал, сэндвич хавтан ашиглан угсармал ханатай хувилбарыг боловсруулж үйлдвэрлэсэн. Мөн Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн ЭКОСАН-ыг нэвтрүүлэх ажлыг дэмжсэн дүгнэлт гаргасан.

Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаа

1. GTZ-ийн сайжруулсан зуух

ГТХАН тус хөтөлбөр нь ердийн болон Дэлхийн Банкны зууханд дүн шинжилгээ хийж, оршиж буй дутагдлыг илрүүлж тэдгээрийг өөрчлөн сайжруулсан болно. Сайжруулсан GTZ-ийн ердийн зуух нь дараах давуу талтай:

Шамотон тоосгон (говьд байдаг каолин шаврыг ашиглан хийсэн) доторлогоо хийх замаар дулаанаа хадгалах чадварыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлсэн.

- Шаталтын анхдагч агаар
- Шаталтын хоёрдагч агаар (бүрэн шаталтыг дэмжих нэмэлт суваг)

GTZ-ийн сайжруулсан эхний зуухыг ШУА-ийн Физик-техникийн хүрээлэнд туршсан бөгөөд ердийн зуухтай харьцуулахад дараах үр

дүн гарсан:

- Түлшний хэмнэлт 32,5%
- Дулаан хадгалах чадвар хоёр дахин нэмэгдсэн
- Хорт хийн ялгарал 30% багассан

Хоёр дахь үеийн GTZ-ийн сайжруулсан зуухны үзүүлэлтүүдийг тогтоох (илүү өндөр дулаан хадгалах чадвартай, хоёрдагч агаарын сунгагтайгаар үйлдвэрлэсэн) туршилтын ажлыг ШУТИС гүйцэтгэж бийгаа.

Энэхүү шинэчилсэн зуухны үнэ 95000 төгрөг болж байгаа бөгөөд хөтөлбөрийн дэмжлэг хяналтын дор дотоодын нэг компани үйлдвэрлэж байна. Одоогийн байдлаар энэ зуухыг WORLD VISION төрөг хэд хэдэн олон улсын байгууллага худалдан авсан. Зуухны дагуу талыг олон нийтэд сурталчилах зорилгоор 2 удаа олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулсан. Мөн жуулчны баазад зориулсан түлшинд хэмнэлттэй, дулаанаа удаан хадгалдаг, утаа бага ялгаруулдаг зуухны хувилбарыг гаргаад байна. Зуухыг олон тоогоор үйлдвэрлэх боломжийг хязгаарлаж буй хүчин зүйл бол каолиныг шатаах, шамотон тоосго үйлдвэрлэх явдал болж байна.

2. Агаарын бохирдлыг хэмжих станц

2008 онд тус хөтөлбөрийн шугамаар ХБНГУ-аас агаарын бохирдлыг хэмжих 4 станцыг оруулж ирнэ. Энэ нь станцууд нь дараах зүйлийг хэмжинэ. Үүнд:

- Озон буюу O3
- Хүхрийн дутуу исэл SO2
- Азотын исэл NO2
- Угаарын хий CO
- Тоосжилт PM 10

Эрэлтэд нийцсэн мэргэжлийн боловсрол, сургалт төсөл

Сургалт

Төв болон орон нутгийн МСҮТ-ийн 60 багш, сургагч нарт зориулсан ажлын байрны ур чадвар эзэмшүүлэх сургалтыг 5 төрлийн мэргэжлээр зохион байгуулсан. Сургалтыг 2007 оны 1-р сарын 22-ноос 2-р сарын 9-ний хооронд Улаанбаатар хотын Барилгын коллеж дээр зохион байгуулсан.

Мөн Барилгын биржтэй хамтран 2007 оны 1, 2-р саруудад хуурай шавардлага, сантехник, цахилгааны угсралт, плитаны ажлын үзүүлэх сургалтыг барилгын компаниудад зориулан 3 удаа зохион байгуулсан.

Байгалийн чулуун зам тавих ажлын байрны сургалтыг 2007 оны 6-10 дугаар сарын хооронд зохион байгуулсан. (Чойжин ламын музей, БХБНААҮТөв, Гандантэгчэнлин хийд зэрэг газар)

Даланзадгад хотын МСҮТөвийн дадлагын байр барих 3 долоо хоногийн барилга угсралтын практик сургалтыг 2007 оны 6-р сард зохион байгуулсан.

Угсармал орон сууцны барилгын дулаалга болон техникийн шинэчлэл хийх засварын ажлын явцад ажлын байрны сургалт зохион байгуулсан. (2007 оны 7-10 дугаар сарын хооронд Монголын барилгын 5 компани хамрагдсан)

Дарханы МБС-ын коллеж дээр 3 долоо хоногийн ажлын байрны сургалтыг цахилгаан, сантехник, халаалт болох хуурай хийцээр 2007 оны 10-р сард зохион байгуулсан. (80 сурагч, 20 багш оролцсон)

Завханы Улиастай хотын МБС-ын коллеж дээр 5 долоо хоногийн бетон арматурын практик сургалтыг 2007 оны 10,11-р сард зохион байгуулсан. (6 багш, 30 сурагч хамрагдсан)

Дарханы МСҮТөв/загвар төв/ дээр 2 долоо хоногийн бетон арматурын практик сургалтыг 2007 оны 12-р сард зохион байгуулсан. (6 багш, 30 сурагч хамрагдсан)

Эрчим хүчний хэмнэлтийг Монголын барилгын салбарт

нэвтрүүлэх, халаалтын эрчим хүчний хэрэглээг бууруулах, орон сууцны тав тухтай орчин бүрдүүлэхийн тулд энэхүү төслийн үүгээс 2007 оны 10-11-р сар, 2008 оны 3-р сард “Барилгын дулаан тусгаалалтын нэгдсэн систем” сэдэвт практик сургалтыг зохион байгуулж, үүнд барилгын салбарын хувийн аж ахуйн нэгжүүдээс 40 хүн хамрагдаж, барилгын дулаан тусгаарлалтын нэгдсэн системийн талаар онолын суурь мэдлэгтэй болж, түүнийгээ практикаар баталгаажуулсан байна.

Бодлого боловсруулах талаар

МБС-ын хуулийн төслийн талаар зөвлөх үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлсэн. Барилгын мэргэжлийн стандартуудын эхний төслийг тодорхойлсон.

Семинар

2007 оны 3-р сарын 27-нд Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний Анхдугаар зөвлөгөөнийг хувийн салбарын оролцоотойгоор МБС-ын салбарын хүрээнд баримтлах бодлого, үзэл баримтлалыг хэлэлцүүлэх зорилгоор БСШУЯ-тай хамтран зохион байгуулсан.

Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний хоёрдугаар зөвлөгөөнийг МБС-ын шинэчлэн найруулсан хуулийн төслийг хэлэлцүүлэх зорилгоор БСШУЯ-тай хамтран сонирхогч талуудын өргөн оролцоотойгоор 2007 оны 11-р сарын 28-нд зохион байгуулсан.

Зөвлөх үйлчилгээ

БСШУЯ-ны шийдвэрээр АХБ-ны Боловсролын салбарын хөгжил-3 хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй Завхан аймгийн Улиастай хотын МСҮТөвийн засварын ажилд чанарын хяналт тавих, мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэж байгаа.

Ерөнхий боловсролын сургуулийн шинэ стандарт, дизайныг боловсруулахад БСШУЯ-нд зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.

Бусад хандивлагч нартай хамтран БСШУЯ-аас зохион байгуулж буй EDCM-ийн уулзалтанд тогтмол оролцож ирсэн.

Бусад зүйл:**Туршлага судлах аялал (чадавхийг хөгжүүлэх чиглэлээр)**

1. "Азийн Хотжилтийн Хөгжлийн Ирээдүйд Хөрөнгө оруулах" нэсэдэвт олон улсын бага хуралд БХБ-ын сайд, Улаанбаатар хотын захирагч бөгөөд Нийслэлийн засаг дарга нарын 8 хүний бүрэлдхүүнтэй ажлын хэсгийн аялалыг зохион байгуулсан (АХБ-ны төв байр, Манил, 2007 оны 2-р сарын 5-6.)
2. Үл хөдлөх хөрөнгө барьцаалах үйл ажиллагаа, орон сууцны санхүүжилтийн талаар туршлага судлах зорилгоор 10 хүний бүрэлдэхүүнтэй багийг 2007 оны 2-р сард Казахстан улсад аялуулсан.
3. АНУ-ын Нью-Йорк хотод болсон "Mongolia investment Forum"-д оролцуулахаар БХБЯ-ны төлөөлөгчдийг 2007 оны 3-р сард явуулсан.
4. БХБЯ-ны 3 төлөөлөгч, НЗДТГ-ын 2 төлөөлөгч ХБНГУ-ын Засгийн газар, ГТХАН-ийн урилгаар 2007 оны 10-р сарын 29-өөс 11-р сарын 4-ний хооронд Бонн, Берлин хоттой харилцаа тогтоох зорилгоор ХБНГУ-д зочилсон. Аялалын хүрээнд хот төлөвлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга туршлага, санхүүгийн менежмент, түүхийн дурсгалт барилга байгууламжийг хамгаалах, хатуу, шингэн болон аюултай хог хаягдлыг зайлуулах, боловсруулах байгаль орчинд халгүй технологи, менежментийн бүтцийг нэвтрүүлэх, угсармал орон сууцны барилгыг шинэчлэн засварлах чиглэлээр туршлага солилцсон болно. Мөн Кельн хотын технологийн паркийн үйл ажиллагаатай танилцсан.

Хот байгуулалтын ажлын баг/Техникийн хорооны хуралдаан

1. 2007 оны 4-р сард зохион байгуулсан Техникийн хорооны хуралдааны дагуу Монгол Улсын Сангийн яам болон Дэлхийн банкны нэрийн өмнөөс хандивлагч болон хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран Хот байгуулалтын бүлгийг бий болгосон.
2. Тус хуралдааныг удирдах бүрэлдэхүүнд орох БХБЯ-ны дэмжлэгтэйгээр 2008 оны 1-р сард болох дараагийн Хот байгуулалтын бүлгийн хуралдааны бэлтгэл ажлыг хангана.

Ажлын байрны сургалт (чадавхи бэхжүүлэх)

Монголын архитекторуудад ArchiCAD ашиглах, инженерүүдэд SAP болон ETABS программ хангамжийг ашиглах сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна

Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран ажиллах

Хамтын ажиллагааг албан ёсоор баталгаажуулж тодорхой болгох зорилгоор Нийслэлийн ЗДТГ-тай харилцан ойлголцлын Санамж бичигт 2007 оны 4-р сарын 12-нд гарын үсэг зурсан.

Оффисийн зориулалтаар нэмэлт талбай бий болгох

Ажлын байрны сургалтыг зохион байгуулах байдлаар хөтөлбөрийн оффисийн талбайг нэмэгдүүлэх зорилгоор БХБНААҮТөвийн байранд зарим өрөө тасалгаанд засвар хийсэн.

Улаанбаатар хотын бичил мужлалын зураглал

Зарим байгууллагын зүгээс GTZ-ийн Хөтөлбөрт Улаанбаатар хотын бичил мужлалын зураглалыг боловсруулж ашиглахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх хүсэлт гаргасан. Хотын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулахаас өмнө ихэвчлэн бичил мужлалын зураглалыг боловсруулж ашигладаг. ЖАЙКА-гийн зүгээс нийслэл хотыг хөгжүүлэх шинэ мастер төлөвлөгөөг боловсруулахаар төлөвлөж буй энэ шатанд БХБЯ болон Нийслэлийн ЗДТГ-ын зүгээс энэ чиглэлээр санал бодлоо илэрхийлэхийг хүлээж байна.

Чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагаа

Шинэ мэргэжил бий болгох байдлаар байгалийн чулуун замыг нэвтрүүлэх,

Талбайн сургалтыг Чойжин ламын музей, БХБНААҮТөв, Гандантэгчэнлин хийд зэрэг газар зохион байгуулсан. Гар ажиллагаа ихтэй тул ажлын байр нэмэгдүүлнэ, орчны тохижилт, өнгө үзэмжийг дээшлүүлнэ, засвар үйлчилгээ бараг шаарддаггүй бат бэх чанартай, хүйтэнд тэсвэртэй зам, олдоц ихтэй орон нутгийн материал, орд газар нь Төв аймгийн Авдрант зэрэг газар байдаг. БХБНААҮТөвийн 3-р давхрын корридорыг ажлын байрны сургалтаар шинэчлэн засварласан.

Олон нийттэй харьцах, сурталчилгаа

Хөтөлбөрийн үйл ажиллагааг Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ТВ-ээр идэвхитэй сурталчилах үйл ажиллагаа явуулсан. Брошюр, зурагт хуудас, танилцуулах материалуудыг монгол, англи, герман хэл дээр боловсруулж бэлэн болгосон. Угсармал сууцны дулаалга болон техникийн шинэчлэлийн загвар төсөл, сайжруулсан зуух, дулаалгын нэгдсэн систем, байгалийн чулуун зам тавих сургалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх цуврал нэвтрүүлэг, нийтлэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж байна.

Орон нутгийн барилгын материалын ЖДҮ-ийг дэмжих Мастер төлөвлөгөө

ГТХАН-ийн хөтөлбөр БХБЯ-нд Орон нутгийн барилгын материалын ЖДҮ-ийг дэмжих Мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлсэн бөгөөд түүнийг Засгийн газар өргөн барьсан болно.

Барилгын салбарын мэргэжилтэй ажилчин, инженер- техникийн ажилтан бэлтгэх Мастер төлөвлөгөө

БХБЯ нь Засгийн газарт өргөн барихаар Барилгын салбарын мэргэжилтэй ажилчин, инженер-техникийн ажилтан бэлтгэх Мастер төлөвлөгөөг ГТХАН-ийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр боловсруулж бийгаа.

Үл хөдлөх хөрөнгө барьцаалах тухай хуулийн төсөл

Үл хөдлөх хөрөнгө барьцаалах тухай хуулийн төсөл болон бусад дигалдах хуулийг боловсруулах тал дээр БХБЯ-нд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ.

Барилгын материалын туршилт, сорилын лаборатори байгуулах

ГТХАН-ийн хөтөлбөр нь БХБНААҮТөвд барилгын материалын чанарыг сайжруулах зорилгоор барилгын материалын туршилт, сорилын лаборатори байгуулахад дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн болно. (зөвлөх үйлчилгээ)

Барилгын салбарын үнэ бүрдэлт, төсвийн тогтолцоог шинэчлэх

ГТХАН-ийн хөтөлбөр нь олон улсын стандартад нийцүүлэн

барилгын салбарын үнэ бүрдэлт, төсвийн тогтолцоог шинэчлэх чиглэлээр БХБНААҮТөвтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна. Тухайн ажлыг хэрэгжүүлэх багийг удахгүй бүрдүүлнэ.

Түүхийн дурсгалт барилга байгууламжийг хамгаалах

Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн захиргаа ГТХАН-ийн хөтөлбөрт хийдийн гол барилга байгууламжийг шинэчлэн засварлах, давхарлах боломжийн талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг хүссэн болно. Хүсэлтийн дагуу тус Хөтөлбөр нь БХБНААҮТөв болон "Таван үндэс" ХХК-тай хамтран дээрх ажлыг хэрэгжүүлэх боломжийг судалах зорилгоор техникийн дүгнэлт гаргуулж хийдийн захиргаанд албан ёсоор хүргүүлсэн.⁵⁶

14. Цахилгаан станцын боловсон хүчнийг сургах төсөл

1998 оны 3-р сараас 2006 он хүртэл Монгол Улсын Дэд Бүтцийн Яам (ДБЯ)-тай хамтран Эрчим хүчний удирдах газар(ЭХУГ)-т хэрэгжүүлсэн 6,21 сая еврогийн өртөгтэй⁵⁷ төсөл юм.

Манай орны уур амьсгал нь эх газрын эрс тэс, өвөл нь хахир хүйтэн тул дулаан, цахилгаанаар найдвартай хангах явдал ялангуяа нийслэл Улаанбаатарын хувьд амин чухал ач холбогдолтой юм. Гэвч цахилгаан эрчим хүчийг төдийгүй төвийн халаалтыг хязгаарлах, таслах явдал тохиолдсоор байгаа төдийгүй энэ нь эдийн засгийн ихээхэн хохирлыг авчирдаг байв. Үүний гол шалтгаан нь тоног төхөөрөмжийн элэгдэл бөгөөд үүнд ялангуяа тухайн ажлыг хариуцсан ажилтны мэдлэг чадвар сул байгаагаас үүдэлтэйгээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, арчилгааны горим алдагдаж буй явдал нь тоног төхөөрөмжийн элэгдлийг түргэсгэж байв.

Иймд уг төслийн зорилго нь Монголын 7 цахилгаан станцын байгууламжийн үйлчилгээ, арчилгааг сайжруулахад чиглэсэн сургалтын болон мэргэжил дээшлүүлэх арга хэмжээ авахад оршиж

⁵⁶ Projektliste Mongolei, im Stand August 2005, BMZ

⁵⁷ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Ausbildung von Kraftwerkpersonal GTZ.-Office Ulaanbaatar, S. 33-36.

байв. Үйлдвэрийн ба арчилгааны горимын ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх нь үйлдвэрлэлийн ослыг багасгах нэг урьдчилсан нөхцөл болох ажээ. Энэ төслийн зорилгод хүрэхийн тулд,

- Ажилчдыг сургах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах:
- Зориулалтын сургалтын төвийг бэлтгэх:

Эрчим хүчний удирдах газрын сургалтын төвийг ЭХУГ-тай хамтран 70.000 ам.доллараар өөрчлөн засварлаж, 700.000 ам.долларын лаборатори болон багаж төхөөрөмж, үзүүлэн таниулах материал, сургалтын хэрэгсэл зэргийг суурилуулсан.

- Зохих сургалтын арга хэмжээг авах, мөн монгол сургагч багш нарт мэргэжлийн болон заах арга зүйн сургалтыг явуулах:

Үүнд, станцуудаас сонгож авчирсан 10 монгол инженер, мастерт богино хугацааны герман мэргэжилтэн нараар хичээл заалгаж, тэднийг мэргэжлийн болон заах арга зүйн хувьд сургаж бэлтгэсэн. Мэдлэгийг дамжуулах орчин үеийн үр ашигтай аргыг хэрэглэхэд зориулж нэлээдгүй материалыг монгол хэлнээ орчуулсан. 7 цахилгаан станцын халаах, дулаан дамжуулах, цахилгаан дамжуулах хэсгийн арчилгааны горимын ажилчдыг сургалтын төвд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулсан. Богино хугацааны герман мэргэжилтнүүд 7 станцын машин механизмын ажилчдын мэргэжил дээшлүүлэх сургалтанд зориулж 25 сургагчийг мэргэжлийн хувьд болон заах аргын хувьд сургаж бэлтгэсэн. Станц бүрийн онцлогоос шалтгаалж, уг сургалтыг цаашид станц тус бүр дээр бэлтгэж явуулж байна. Сургалтыг хамгийн гол нь лабораторид явуулж байгаа учраас практиктай нягт уялдуулж чадсанаараа ач холбогдолтой юм. Урьд нь сургалтыг танхимд явуулдаг байсан тул практикаас хол хөндий байсан ажээ. Үүнээс гадна ЭХУГ-ын мэргэжлийн ажилчид, мастер, инженер нарыг ч мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулсан байна.⁵⁸

⁵⁸ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Ausbildung von Kraftwerkpersonal GTZ.-Office Ulaanbaatar, S. 33-36.

15. Мэргэжлийн боловсролыг хөхиүлэн дэмжих төсөл

2000 оны 1-р сараас 2002 оны 12-р сар хүртэл Монгол Улсын БСШУЯ дээр 3 сая ДМ-ийн өртөгтэй хэрэгжсэн төсөл юм.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг нуран унаснаар ямар мэргэжлээр хэдэн хүн сургах, мэргэжил дээшлүүлэхийг дээрээс хатуу тогтоож өгдөг байсан үе улиран өнгөрч, 1991, 1995 оны Боловсролын хууль, 1998 оны 3-р сарын 25-ны өдрийн "Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 41 тоот тогтоол тус тус гарч мэргэжлийн боловсролыг эзэмших сонголтыг чөлөөтэй болгож өгсөн.

Гэвч шилжилтийн жилүүдэд хуучин тогтолцооны үеийн аж үйлдвэр, хөдөө аж ахуй, дэд бүтцийн салбарууд задарч, дийлэнх үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх чадваргүйн улмаас хаалгаа барьж олон мянган хүн ажлын байргүй болсон нь техник, мэргэжлийн боловсролын хэрэгцээг бууруулахад хүргэж байв.

Харин шилжилтийн үйл явц цэгцрэх тутам олон тооны хувийн аж ахуй, жижиг дунд үйлдвэр олноор бий болж, мэргэжилтэй ажилчдын эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэж эхлэх үед мэргэжлийн боловсрол эдийн засгаас хэдийнээ тасарч хаягдсан, мэргэжлийн боловсролд хаашаа яаж хөгжих тухай төсөөлөл, туршлага дутагдмал, санхүүжилт, хангамж зэрэг асуудал нь хүндэрсэн, мэргэжлийн боловсролын сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд практик сургалт маш доод төвшинд явагдаж байсан зэрэг хүндрэлтэй асуудлууд хуримтлагдсан байлаа.

Иймд энэ төслийн эхний үе шатанд гар урлал-техник, үйлчилгээний салбарт мэргэжлийн боловсрол, мэргэжил дээшлүүлэх сургалтыг сайжруулах хөтөлбөрийг бий болгох, харилцан уялдуулах явдлыг зорилгоо болгож байв. Хэдийгээр төсөл 3 жил хэрэгжихээр төлөвлөсөн ч эхний 18 сарын хугацаанд төсөл хэрхэн хэрэгжих зүг чиг, арга замыг нарийвчлан тогтоохоор төлөвлөсөн байна. Үүнд:

- Мэргэжлийн боловсролыг өөрчлөн шинэчлэх, дахин сэргээхэд шаардагдах арга хэмжээг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх

төлөвлөгөө гаргах, холбогдох бусад байгууллагуудтай хамтран мэргэжлийн боловсролыг практик уялдаа холбоо бүхий болгож өөрчлөн зохион байгуулах талаар хэд хэдэн хувилбар бүхий хөтөлбөрийг боловсруулах:

Үүнд тухайлбал 2000 оны 4-р сард “Мэргэжлийн стандарт, сургалтын хөтөлбөр” сэдвийн хүрээнд аж ахуйн нэгж, яамд, байгууллагуудыг оролцуулан мэргэжлийн боловсролын салбарын мэргэжлийн ба удирдах боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх асуудлаар хоёр өдрийн уулзалт зохион байгуулсан байна. 2000 оны 6-р сарын эцсээр “Мэргэжлийн боловсролын методик ба дидактик” нэртэй хоёр дахь арга хэмжээг зохион байгуулсан ба энэ үеэр “Хөдөлмөрийн зах зээлд анализ хийх нь” сэдэвт тусгай семинарууд явагджээ.

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, гар урлал-техник, үйлчилгээний салбарт шаардлагатай буй мэргэжлийн чиглэлийг тогтоох:

2000 оны 6-р сард Монголын мэргэжлийн боловсролын тухай хийсэн 100 хуудас анализыг бэлтгэж, төсөлд оролцогчдод тараасан байна. Үүнд мөн Монголын хөдөлмөрийн зах зээлийн тухай дэлгэрэнгүй анализ багтжээ.

- Монголын мэргэжлийн боловсролын өнөөгийн байгууллагуудын нөөц боломжинд дүгнэлт хийж, сургалтын арга хэмжээг зохион байгуулах чадвартай байгууллагыг тогтоох:

2000 онд “Зочид буудал, ресторанд ажиллах мэргэжлийн боловсон хүчний анхан шатны сургалт” буюу “тогооч”, “рестораны мэргэжилтэн”, “зочид буудлын мэргэжилтэн” бэлтгэх 2 жилийн мэргэжлийн сургалтыг зохион байгуулах ажил хийгдсэн. Үүнд, тухайлбал тэдэнд багшлах хүмүүсийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж бэлтгэсний зэрэгцээ практиктай хосолсон сургалтын шинэ стандартыг бий болгох талаар сургалт зохион байгуулсан. Анхны сургалт 2000 оны 9-р сард эхэлсэн бөгөөд 2001 онд 33 оюутан суралцаж байв. Оюутны тоо дадлага хийлгэх хүсэлтэй үйлдвэрийн тооноос шууд хамааралтай ажээ.⁵⁹

⁵⁹ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Förderung der beruflichen Bildung in der Mongolei, GTZ.-Office Ulaanbaatar, S. 27-29.

16. Нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах төсөл

Төслийн эхний үе шат

Нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах төслийг 1998 оны 5-р сараас Эрүүл мэндийн яам /ЭМЯ/-тай хамтран Улаанбаатар, Төв, Сэлэнгэ Өмнөговь аймагт хэрэгжүүлсэн. Төсөл нийт 10 гаруй жил үргэлжилсэн бөгөөд төслийн эхний үе шат 4 сая ДМ-ийн өртөгтэй хэрэгжиж 2001 оны 10-р сард дуусчээ.

Социализмын үед Монголд хүн амын өсөлтийг төрөөс дэмжиж байсан боловч гэр бүл төлөвлөлтийн асуудал хоцрогдонгуй, үр хөндөлт эмнэлгийн заалтаар зөвшөөрөгддөг хязгаарлагдмал нөхцөлтэй байв. Гэтэл шилжилтийн нийгмийн үед нөхцөл байдал өөрчлөгдөж, гэр бүлээ төлөвлөх эрэлт хэрэгцээ бий болсон боловч жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл, эмийн хангамж хүрэлцээгүй, эмнэлгийн тоног төхөөрөмж дутагдалтай, санхүүжилтийн бэрхшээл, тогтолцооны гажуудал, менежментийн асуудлууд байсны зэрэгцээ эмнэлгийн мэргэжилтнүүд хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх, тайлбарлан таниулах, итгэл үнэмшил бий болгох орчин үеийн харилцааны арга барилтай танилцаагүй зэрэг дутагдлууд оршиж байлаа. Мөн эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр эхийн эндэгдэл 1995 онд 100 мянга, амьд төрөлтөнд 185 байсан нь харьцангуй өндөр төдийгүй үр хөндөлт, өсвөр насны охидын жирэмслэлт, залуучуудын дунд бэлгийн замын халдварт өвчнүүд байнга нэмэгдсээр байв.

Ийм нөхцөлд төслийн зүгээс Улаанбаатар хотын нэг дүүрэг, 3 аймгийн төв, 12 сумыг сонгон авч нийт 270.000 оршин суугчдыг хамарсан үйл ажиллагааг явуулж, тэнд байгаа эрэгтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах, залуучуудын энэ талын мэдлэгийг нэмэгдүүлэхэд түлхэц өгөх, эхийн эндэгдэл, үр хөндөлтийг бууруулах нь төслийн үндсэн зорилго байлаа. Энэхүү зорилгод хүрэхийн тулд:

- Бодлого төлөвлөлтийн түвшинд - Эрүүл мэндийн яаманд бодлогын болон үйл ажиллагааны тал дээр дэмжлэг үзүүлэх /энэ ажлын хүрээнд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн Advocacy Training буюу бодлого тодорхойлогч болон шийдвэр гаргагч нарт шаардагдах чухал мэдээлэл хүргэх сургалтыг

76 удирдах ажилтанд зориулан зохион байгуулах, Эрүүл мэндийн яамны энэ талын статистикийн тоон мэдээллийг хадгалах, боловсруулах тогтолцоог боловсронгуй болгох талаар зөвлөгөө өгсөн/

- Хэрэгжүүлэх байгууллагын түвшинд - Төсөлд хамрагдсан аймаг, сумдын хүн амд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа эмч нарт хариуцсан ажил мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх, зөвлөлгөө өгөх чиглэлийн сургалтанд хамруулах, нэн шаардлагатай эм, эмнэлгийн багаж хэрэгслээр хангах, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд голлон анхаарсан байна.

Тухайлбал: Нөхөн үржихүйн тусламж, оношлогоо эмчилгээний орчин үеийн арга техник, сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх, удирдлага менежментийн чиглэлээр 78 эмчийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, "мастер сургагч" болгон мэргэшүүлжээ. Мөн өдгээр сургагч багш нар нь 395 эмч, эх баригч, сувилагч нарыг сургаж, улмаар бэлгийн замын халдварт өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээний орчин үеийн арга менежментээр хөдөөгийн сумын эмнэлгийн 35 эмч мэргэжилтний мэргэжлийг дээшлүүлэх сургалт хийжээ. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг "баг"-нар үзүүлэх, бусад чиглэлийн эмч нартай хамтран ажиллах, орон нутгийн оршин суугчдын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэхийг чармайж байлаа.

- Зорилтот бүлгийн түвшинд - Өсвөр насныхан болон залуучуудад аюулгүй бэлгийн харилцааны талаар ухуулан ойлгуулах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг нь дээшлүүлэх, итгэл үнэмшил бий болгох, хандлагыг өөрчлөх сурталчилгааны стратегийг боловсруулах /Уг ажлын хүрээнд ЕБС-ийн багш нар, төрийн бус байгууллагын идэвхтэн зэрэг 98 хүн оролцсон Sexuality and Sexuality education сургалтыг хийж, Peer educators буюу "Үе тэнгийн сургагч" багшаар 78 охид хөвгүүдийг сургаж, IEG Core Group буюу эрүүл мэндийн ухуулан сурталчилгаа хүмүүжлийн ажил эрхлэх 12 хүүхдийн бүрэлдэхүүнтэй бүлэг багуудыг бэлтгэсэн байна/.⁶⁰

⁶⁰ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Verbesserung der Reproduktion Gesundheit, GTZ.-Office Ulaanbaatar, S. 45-48.

Төслийн хоёрдугаар үе шат

Энэ төслийн хоёрдугаар үе шат нь 2001 оны 8-р сараас 2007 оны 4-р сар хүртэл 3,3 сая еврогийн өртөгтэй хэрэгжсэн юм. Уг төсөл нь Төв, Сэлэнгэ, Өмнөговь аймаг, нийслэлийн Налайх дүүрэгт цааш үргэлжлэхийн зэрэгцээ Завхан, Сүхбаатар аймаг, нийслэлийн Хануул, Сүхбаатар дүүргийн 333.000 гаруй оршин суугчид буюу нийт хүн амын 14%-ийг хамарч хэрэгжсэн ажээ.⁶¹

Төслийн зорилго нь төслийн 1-р шатанд хэрэгжсэн арга хэмжээг чанаржуулан сайжруулах, тогтворжилтийг хангах, гэр бүлийн доторх эрэгтэй, эмэгтэйчүүдийн нөхөн эрүүл мэндийн байдлыг сайжруулах, ялангуяа өсвөр залуу үеийг тэдний насны онцлогт тохируулан ХДХВ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, аюулгүй бэлгийн харьцааны талаар ухуулан ойлгуулах нь чухал байсан бөгөөд үүний тулд:

- Эрүүл мэндийн яамны хэрэгжүүлж байгаа Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөртэй үйл ажиллагаагаа нягт уялдуулах, хүний нөөцийн чадавхийг сайжруулж хөгжүүлэх болон менежментийг боловсронгуй болгох
- Төсөл хэрэгжиж буй газруудын энэ чиглэлээр ажиллаж буй албадыг бэхжүүлэх, тэдгээрийн оношлогоо, эмчилгээ, зөвлөгөө, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанарыг сайжруулж, нэн шаардлагатай эм хэрэгслээр хангах

Тухайлбал, төсөл хэрэгжиж буй аймгийн төв, сум, сум дундын эмнэлгүүдийг стандартад нийцүүлэн, дэд бүтцийг сайжруулахад онцлон анхаарч,

1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд "НҮЭМ-ийн цогцолбор, эхчүүдийн амрах байр байгуулж ажиллуулах
2. Сумдын эмнэлэгт сургалтын танхим, эхчүүдийн амрах байр, нарны эрчим хүчээр ажиллах халуун усыг байгуулах
3. Клиникийн нэгдүгээр амаржих газрыг сургалтын бааз болгон тохижуулж, төсөлд хамрагдсан аймаг, сум багийн эмч нарын мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоо бий болгож, жилд 1-3 удаа сургах зэрэг арга хэмжээ авч байв.⁶²

⁶¹ Die GTZ in der Mongolei. Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne. Programm Regionale Wirtschaftsförderung, GTZ GmbH, Ulaanbaatar, 2006, S.23-24.

⁶² Хөхтөмөр, Э., "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн төсөл ажлаа дүгнэв", Зууны мэдээ, 2007.11.21. №273; ГТХАН-ийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын материал, Улаанбаатар, 2008.

- Шийдвэр гаргах үйл ажиллагаанд өөрөө өөртөө туслах бүлэг, орон нутгийн сайн дурын идэвх санаачлага гаргагсад болон сум орон нутгийнхны оролцоог нэмэгдүүлэх зэргээр ажилласан байна

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндсэн сэдвүүдээр системтэй ойлголт өгч, хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх, "Үе тэнгийн сургагч" хөтөлбөрөөр ахлах ангийн 4500 сурагчийг сургагчаар бэлтгэж чаджээ.

Харилцан ярилцах замаар бэлгийн харьцаа болон амьдралын үнэт зүйлсийн талаар мэдлэг олжавах оролцооны аргад тулгуурласан "Мэдлэгийн өртөө" сургалтыг Улаанбаатар хотын ЕБС-иуд дээр тогтмол зохион байгуулж, 10.000 гаруй сурагчийг хамруулжээ.

Гал голомт төрийн бус байгууллагатай хамтран хугацаат цэрэг, офицер, улирагсад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 28.000 гаруй оролцогчийг хамруулж, гарын авлага, ном товхимлоор хангасан байна.⁶³

Төслийн үр дүнг нотлон харуулах нэгэн үзүүлэлт бол эхийн эндэгдэл, үр хөндөлтийн тоог бууруулах асуудал байв. Манай улсад эхийн эндэгдэл 100.000 амьд төрөлтөд 158 байсан нь 2006 онд 69,7, ГТХАН-ийн төсөл хэрэгжсэн бүс нутагт 53,4 болж буурчээ. 2000 онд улсын хэмжээнд 1000 амьд төрөлтөд 230 үр хөндөлт ноогдож байв. 2006 онд энэ үзүүлэлт 265,8 болж өссөн бол ГТХАН-ийн төсөл хэрэгжсэн аймгуудад 134 болж буурсан нь уг төслөөр зарим сайн үр дүнд хүрснийг илтгэж байна.⁶⁴

Цаашид "Нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих төсөл"-ийн гуравдугаар үе шат 2007 оны 4-р сараас 2009 оны 4-р сар хүртэл үргэлжлэхдээ хүний дархлал хомсдлын вирустэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг дэмжихэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэх юм.

⁶³ Хөхтөмөр, Э., "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн төсөл ажлаа дүгнэл". Зууна мэтээ, 2007.11.21. №273; ГТХАН-ийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын материал, Улаанбаатар, 2008.

⁶⁴ Хөхтөмөр, Э., "Үлдэцтэй, наалдацтай нэгэн төслийн тухай огуулахгүй", Онолбар, 2007.04.30. №100(3058).

20. Байгаль хамгаалал ба хязгаар нутгийн хөгжил төсөл

Төслийн нэгдүгээр үе шат

1995 оны 4-р сараас 2002 оны 9-р сар хүртэл Монгол Улсын Байгаль Орчны Яам (БОЯ), Тусгай хамгаалттай газрын үндэсний алба, Горхи-Тэрэлж, Говь Гурван Сайханы байгалийн цогцолбор газрын захиргаа, Хан Хэнтийн дархан цаазат газрын захиргаатай хамтран хэрэгжүүлсэн 11,6 сая хүртэлх ДМ-ийн өртөгтэй төсөл юм. Төслийн нийт хэрэгжих хугацаа 12 жил бөгөөд төслийн эхний үе шат 2002 оны 9-р сард дуусчээ.

Монгол нутаг нь тайга, тал хээр, говь зэрэгцэн оршдог маш өвөрмөц байгалийн тогтолцоотой, ховор нандин ургамал, амьтан элбэгтэй газар юм. Шилжилтийн үеийн шуурганд зах зээлээс алсгагдаж тусгаарлагдсан, засаг захиргааны хяналт сул хөдөө нутагт ажилгүйдлийн улмаас ядууралд өртөх нь элбэгшсэн хүмүүс тусгай хамгаалалттай болон дархан цаазтай газрын баялагт ч хамаагүй халдах болсон байв. Иймд экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад чухал ач холбогдолтой дархан цаазтай болон тусгай хамгаалалттай газрыг хамгаалах, Монголын газар нутгийн 11%-ийг эзэлж байсан тусгай хамгаалалттай газрын талбайг 30% хүргэж нэмэгдүүлэх шаардлагатай байв.

Иймд уг төслийг Хан-Хэнтийн дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар, Говь-Гурван сайхны байгалийн цогцолбор газарт хэрэгжүүлэхээр сонгож авсан. Төслийн зорилго нь төсөл хэрэгжиж буй газруудын нийгэм-эдийн засгийн, бүтцийн болон эрх зүйн аспектын хөгжлийг тэдгээрийн зохих байгууллагуудын төлөвлөж буй төсөл, хөтөлбөр зэрэг арга хэмжээтэй уялдуулан зохицуулах замаар төсөл хэрэгжиж буй газарт хуралдсан олон асуудлыг шийдэх нэгдмэл бүтэц бий болгох явдал ажээ. Өөрөөр хэлбэл, нутгийн засаг захиргаа, оршин суугчид, бусад сонирхлын бүлгүүд идэвхтэй хамтран ажиллах хосолмол менежментийг эдгээр хамгаалалттай газруудад бий болгож хөгжүүлэхийг тус төслийн зүгээс зорьсон байна. Үүний тулд хийсэн ажлуудыг дурдвал,

- Эрх зүйн орчин нөхцлийг сайжруулах:

Эхний үе шат буюу 1995-1998 онд байгаль орчны бодлогын болон хууль тогтоох чиглэлээр зөвлөгөө өгөхөд төслийн зүгээс анхаарлаа хандуулсан байна. Тухайлбал, "Тусгай хамгаалалттай газрын мастер төлөвлөгөө"-г боловсруулан, түүний дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, "Хязгаар нутгийг хөгжүүлэх хууль", "Аялал жуулчлалын хууль"-ийг боловсруулах, "Community Based Natural Resource Management"-ийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргахад энэхүү төсөл нь чухал хувь нэмэр оруулсан билээ.

- Орон нутгийн болон үндэсний төвшинд эдгээр хамгаалалттай газрын менежментийн нөөц чадавхийг бий болгон өргөжүүлэх:

Төслийн хоёрдугаар үе шатанд эдгээр хамгаалалттай газарт хяналт, хамгаалалтын үр ашигтай арга хэмжээг авахад анхаарлаа хандуулсны үрээр тухайн газрын баялгийг зүй зохистойгоор ашиглах загварыг бий болгон хөгжүүлсэн. Тухайлбал, байгаль орчинд халгаагүй аялал жуулчлалыг хөгжүүлэх, говийн ус, бэлчээрийн менежментийг хөтлөх, ой модны аж ахуй, ойн гаралтай модон бус бүтээгдэхүүнийг хэрхэн ашиглах талаар санал санаачлага гаргаж, зөвлөгөө өгсөн. Мөн нутгийн оршин суугчид гэнэтийн аюулын үед бие даан ямар арга хэмжээ авах тухай арга замыг зааж өгсөн. Цаашид нутгийн оршин суугчдын идэвх санаачлагыг байгалийн баялгийн хамтын оролцооны менежмент болгон хөгжүүлэхэд анхаарч дэмжлэг үзүүлсэн. Үүний үр дүнд Говь-Гурван сайхны байгалийн цогцолбор газарт бий болсон нутгийн оршин суугчдын өөрөө өөртөө туслах бүлэг нь хэдийнээ хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын шинжтэй болсон байна. 1999 онд эдгээр бүсэд нэвтрэх замуудад хяналтын цэгийг байгуулж, бүсийн менежментын дэд бүтцийг сайжруулсны зэрэгцээ мэдээлэл, сургалтын төвүүдийг байгуулж, бэхжүүлсэн. Яаралтай үед хоорондоо холбоо барих радио сүлжээтэй болжээ.

- Эдгээр хамгаалалттай бүсэд зориулж менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Хамгаалалттай бүс өөрөө өөрийгөө санхүүжүүлэхэд нэмэр болох зорилгоор жуулчдад зориулсан мэдээллийн товхимол, танилцуулга гаргахад төслийн зүгээс дэмжлэг үзүүлсэн. Цаашид нутгийн оршин суугчдыг татан оролцуулсан хосолмол менежментыг улам бататгахын тулд "Хязгаар нутгийн зөвлөл"-ийг байгуулж, гишүүдийг нь сургалтанд хамруулжээ. Энэхүү

зөвлөл нь нутгийн оршин суугчдыг хамгаалалттай бүсийн үйл ажиллагаатай холбоход чухал үүрэгтэй ажээ.

- Нутгийн оршин суугчдыг орон нутгийнхаа нөөц баялгийг зохистой ашиглаж, хамгаалах чадвартай болгох:

Тухайн нутгийн оршин суугчдын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд зориулж мэдээлэл, сургалтын төвүүдийг байгуулсан. Эсгийгээр бэлэг дурсгалын зүйлс хийх, гутал хийх тухай сургалтын курс ажиллуулж, улмаар түүнийгээ борлуулах болсон. Залуучуудыг хөтөчийн сургалтанд хамруулж, аялал жуулчлалаас орлого олох боломжийг нээж өгсөн. Төсөлд оролцож буй ТББ-ын гишүүдийг тодорхой зорилготойгоор олон улсын болон дотоодын сургалтанд хамруулсан. Говь-Гурван сайханы байгалийн цогцолбор газарт аргалын илчийг сайн барьдаг зуух нэвтрүүлэх замаар уламжлалт түлшээ хэрэглэх явдлыг дэмжихийн зэрэгцээ тус бүсийг Хятад руу явах худалдаачдын хөлнөөс хамгаалах хамгаалалтыг сайжруулахад анхаарал тавьж байв. Хан-Хэнтийн дархан цаазтай газарт ойг хамгаалах, нийгэмд тустайгаар ойн аж ахуйг хөгжүүлэх тал дээр түлхүү арга хэмжээ авсан бол харин Улаанбаатар хотын оршин суугчдын амралтын газар болсон Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт аялал жуулчлалыг зохицуулалттайгаар хөгжүүлэх баримт бичиг болон газар ашиглалтын төлөвлөгөө гаргахад анхаарсан ажээ.⁶⁵

Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой менежмент хөтөлбөр

Төслийн хоёрдугаар үе шат

2002 оны 10-р сараас 2008 оны 6-р сар хүртэл ХБНГУ, Нидерландын хосолмол санхүүжилтийн 8,8 сая еврогийн өртөгтэй хэрэгжсэн төсөл юм.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш байгалийн баялгийг зүй зохисгүй ашиглах явдал газар авсан байлаа. Эл байдалтай тэмцэхэд шаардагдах эрх зүйн орчин энэ үед хэдийнээ

⁶⁵ Хөхтөмөр, Э., “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн төсөл ажлаа дүгнэв”, Зууны мэдээ, 2007.11.21. №273.

бүрдсэн байсан боловч түүнийг хэрэгжүүлэх явцад үндэсний, бүсийн болон орон нутгийн төвшний холбогдох төрийн байгууллагууд, үүнийн оролцогч нарт стратеги, загвар дутагдаж байв.

Иймд энэ төслийн зорилго нь үндэсний, бүсийн болон орон нутгийн төвшний холбогдох төрийн байгууллагууд, хувийн оролцогч нарын хэрэгжүүлж буй байгалийн нөөцийг хамгаалах стратеги, бүрдэл хэсгийг загварчлан бүтэцжүүлэх явдал ажээ. Чингэхдээ доорх үндсэн 5 хэсгээс бүрдэж байна. Үүнд:

- Байгалийн баялгийн төвлөрсөн бус менежментийг хөгжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааны инструментийг бий болгох
- Байгаль орчны хяналт шалгалтыг сайжруулах
- Хангайн уулархаг бүсийг хамгаалах
- Хэнтийн ойт бүсийг хамгаалах
- Говийн талархаг нутгийг хамгаалах

Төслийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлыг дурдвал,

- Байгалийн баялгийг тогтвортой ашиглахын зэрэгцээ байгалиа хамгаалах хөтөлбөр, саналуудыг боловсруулж, төсөл хэрэгжиж буй бүсүүдэд загварчлан хэрэгжүүлэх: Бусад оролцогч нартай хамтран ой, хээрийн менежментийн хөтөлбөрийг боловсруулж, үндэсний хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдуулан холбож чадсан. Ялангуяа Германы Хөгжлийн Албаны 2 мэргэжилтэн ойн менежментийн төлөвлөгөөг бий болгон хэрэгжүүлэх, ойн баялгийг ашиглагчдын бүлгийг байгуулахад дэмжлэг үзүүлсэн. Мөн төслийн зүгээс байгаль хамгаалах хууль, журамд оруулах өөрчлөлтийн тухай саналыг санаачлан боловсруулсан.
- Ойн аж ахуйг тогтвортой ашиглах явдлыг бүх төвшний холбогдох албадтай хамтран дэмжих
- Байгаль хамгаалал, баялгийн менежмент, ойн аж ахуйг хянах үр ашигтай тогтолцоог байгуулахад дэмжлэг үзүүлэх
- Байгаль хамгааллын (ойн аж ахуй, баялгийн менежмент, цөлжилттэй тэмцэх) стратеги, арга замыг оролцогч нартай хамтран томъёолох, үүнийг бүс нутгийн хөгжлийн үзэл

баримтлал, стратегитэй холбон уялдуулах зэрэг болно.⁶⁶

17. Монголын хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчийг дэмжих төсөл

Төслийн эхний үе шат

1998 оны 8-р сараас 2002 оны 3-р сар хүртэл Монгол Улсын ДБХЯ-тай хамтран Сэргээгдэх эрчим хүчний корпорац болон Завхан аймагт хэрэгжүүлсэн 3 сая ДМ-ийн өртөгтэй төсөл юм.

Хүн амын ихээхэн хувийг эзлэх малчид сийрэг, таруу нутаглахтул Монголын хөдөө орон нутгийг эрчим хүчээр хангахдаа овор багатай, төвлөрсөн бус, зарим талаар нүүлгэн суулгаж болохуйц эрчим хүч үйлдвэрлэх байгууламжийг ашиглах нь илүү тохиромжтой юм. Хөдөө орон нутгийг эрчим хүчээр хангах нь тэнд орлого нэмэгдэж, ажлын байр бий болж, Улаанбаатар руу хөврөх нүүдлийн цувааг багасгахад нөлөөлж улмаар орон нутгийн эдийн засгийн байдалд ахиц гаргуулах нэгэн урьдчилсан нөхцөл болох ажээ.

Иймд дунд хугацаанд төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдох төлөвгүй байгаа баруун аймгуудын нэг болох Завхан аймгийг энэ төсөлд хамруулсан байна. Энэ төслийн зорилго нь сэргээгдэх эрчим хүчийг түлхүү хэрэглэж эрчим хүчний хэрэгцээгээ хангахад нь нутгийн оршин суугчдад дэмжлэг үзүүлэх явдал юм. Үүний тулд:

- Сэргээгдэх эрчим хүчийг сурталчлан түгээх хөтөлбөр боловсруулах: Орон нутгийг эрчим хүчээр хангах хөтөлбөр гаргахад шаардагдах мэдээ баримт цуглуулсан.
- Ус, салхи, нарны эрчим хүчийг өргөн дэлгэр ашиглах орчин нөхцлийг сайжруулах: Завханы Улиастайд Монголын сэргээгдэх эрчим хүчний компаниудын бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж, үзэсгэлэнг эхний 9 сарын хугацаанд 2000 гаруй хүн үзэж сонирхжээ. Мөн сэргээгдэх эрчим хүчний мэдээллийг түгээх үүрэг бүхий төлөөлөгчийг сум бүхэнд сонгож, тэдэнд сургалт зохион байгуулсан.

⁶⁶ Mongolisch-deutsche Zusammenarbeit, im Stand Januar 2001, Naturschutz und Randzonenentwicklung, GTZ.-Office Ulaanbaatar, S. 51-54.

- Санхүүжилтийн зохих арга хэрэгслүүдийг олж тогтоох, турших:
- Орон нутагт сэргээгдэх эрчим хүчний анхны үзүүлэн таниулах төслүүдийг хэрэгжүүлэх:
- Сэргээгдэх эрчим хүчний корпорацид дэмжлэг үзүүлэх: Айл гэрийн ажлыг хөнгөвчлөх, эрчим хүчийг үр ашигтай ашиглах үүднээс зарим сэргээгдэх эрчим хүчний шинэ бүтээгдэхүүнүүдийг туршиж зах зээлд нэвтрүүлжээ.⁶⁷

Сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг дэмжих төсөл

Төслийн хоёрдугаар үе шат

2002 оны 4-р сараас 2007 оны 3-р сар хүртэл хэрэгжсэн 6,11 сая еврогийн өртөгтэй төсөл юм. Энэ төсөл нь үндсэндээ “Монголын хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчийг дэмжих төсөл”-ийн үргэлжлэл төсөл ажээ.

Монгол Улс нь эрчим хүчний хангамжийн хувьд асуудалтай улс бөгөөд эрчим хүчний хангамж хөдөө орон нутагт тааруу байгаа нь юуны өмнө тус бүс нутгийн эдийн засгийн хөгжилд төдийгүй хүн ардынх нь өдөр тутмын амьдралд сөргөөр нөлөөлж байна. Хэдийгээр Монгол орон нар, салхи, усны эрчим хүчний нөөц ихтэй боловч, эрчим хүчний эх үүсвэр барихад өртөг харьцангуй өндөр, хүн амын нягтшил маш бага зэрэг бэрхшээлүүд байдаг байна. Иймд энэ төслийн хүрээнд Завхан, Хөвсгөл аймгийг сонгон авч, тэнд сэргээгдэх эрчим хүчний нөөц боломжийг ашиглахад нь дэмжлэг үзүүлэхийг зорилгоо болгосон байна. Төслийн хүрээнд хийгдсэн ажлуудыг дурдвал:

- Бодлогын төвшинд: Үндэсний эрчим хүчний бодлогод сэргээгдэх эрчим хүчийг тусгах тал дээр Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал Засгийн газрын төвшинд байгуулагдсан эрчим хүчний төрөл бүрийн ажлын хэсэг, зөвлөлтэй хамтран ажиллаж, сэргээгдэх эрчим хүчний

⁶⁷ Die GTZ in der Mongolei, Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne, Programm Schutz und Bewirtschaftung natürlicher Ressourcen, GTZ GmbH, Ulaanbaatar, 2006, S.23-24.

талаар шаардагдах мэдээллийг Засгийн газар, парламентын гишүүдэд өгч байв. Мөн сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн төсөл боловсруулахад ТЭХЯ-нд дэмжлэг үзүүлсэн байна.

- Сэргээгдэх эрчим хүчний компаниудын хувьд төслийн зүгээс тэдэнд микро эдийн засгийн болон техникийн зөвлөгөө өгсний зэрэгцээ сэргээгдэх эрчим хүчний гадаадын компаниудтай холбоо тогтооход туслалцаа үзүүлсэн. Сэргээгдэх эрчим хүчний холбоо байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна.
- Хөдөө орон нутагт жижиг боловч хэрэгцээний хэрээр өсч томрох боломжтой, төвлөрсөн бус эрчим хүчний системийг байгуулахад төслийн зүгээс дэмжлэг үзүүлсэн бөгөөд энэ нь хөдөөгийн хэсэг хүн амыг эрчим хүчээр хамгийн үр ашигтайгаар хангах ажээ. Төслийн зүгээс Завхан аймгийн Тосонцэнгэлд үзүүлэн таниулах төслийн хүрээнд 375 кВт-ын чадалтай усан цахилгаан станцыг барьж байгуулж хоёр жилийн хугацаанд 310 гаруй сая төгрөгийн дизелийн түлшний хэмнэлт гаргажээ.
- Үүний зэрэгцээ эрчим хүчний байгууламжийн засвар үйлчилгээ, үйлдвэрлэлд зориулсан техникийн ноу-хау шилжүүлэхийн тулд олон нийтэд зориулсан мэдээллийн арга хэмжээг зохион байгуулж, СЭХ-ний сургалтын төвийг байгуулсан.
- Германы Хөгжлийн Албаны нэг мэргэжилтэн Улиастай, Тосонцэнгэл сумуудын эрчим хүч хангамжийн компанид менежментийн зөвлөхөөр ажиллаж, компьютерт тулгуурласан борлуулалтын тооцооны системийг зохиох, нэвтрүүлэхэд дэмжлэг зөвлөгөө өгсөн.⁶⁸

18. Эрчим хүчний системийн үр ашиг төсөл

2005 оны 10-р сард болсон Монгол-Германы засгийн газар олонд хэлэлцээрийг үндэслэн 2006 оны 9-р сард Германы икийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс ажлын хэсэг

⁶⁸ GTZ in der Mongolei, Zusammenarbeit mit einem Land zwischen Tradition und Moderne, chließung regenerativer Energiequellen, GTZ GmbH, Ulaanbaatar, 2006, S.19-20.

томилогдон ирж судалгаа хийсний үндсэн дээр “Эрчим хүчний үр ашиг” төслийг хэрэгжүүлэх санамж бичигт хоёр тал гарын үсэг зурсан билээ. Уг төслийг хэрэгжүүлэхэд ХБНГУ-ын засгийн газрын зүгээс нийт 1,875 сая еврогийн тусламж олгосон. Төслийн үргэлжлэх хугацаа 3 жил бөгөөд 2008 оноос эхлэн хэрэгжиж байна.

Төслийн үндсэн зорилго нь эрчим хүчний үйлдвэр, компаниуд үр ашиг дээшлүүлэх чадамжаа сайжруулахад дэмжлэг үзүүлэх явдал юм.

Төслийн үйл ажиллагаа нь дулааны цахилгаан станцуудын үр ашгийг дээшлүүлэх (удирдлага ба инженерийн түвшинд), цахилгаан шугам сүлжээний компаниудад үр ашгийг дээшлүүлэх болон монгол улсын эрчим хүчний салбарын бодлогын төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгөх гэсэн үндсэн 3 чиглэлээр хэрэгжих болно. Төслийн хүрээнд ДЦС-4“ ТӨХК „Дархан-ДЦС“ ТӨХК (ДДЦС), „Багануур“ ТӨХК, “ТБЦДС” ТӨХК, „ББЭХС“ ТӨХК, ТЭХЯ, ЭХСХТ, ЭХЗГ, ДҮТ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллана.

Үйл ажиллагааны 1-р хэсэг: Дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээг бууруулах ба ашиглалтын горимийг сайжруулах чиглэлээр турбины конденсаторын хөргөлтийн усны системийн АҮК-ийг сайжруулах технологи, хувьсах зарцуулалттай насос/хөдөлгүүрийн техникийг нэвтрүүлэхэд, дулааны цахилгаан станцуудад нийлүүлж байгаа нүүрсний чанар, нүүрс угаах технологиудыг харьцуулж нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, Германы зүүн хэсгийн ижил төстэй станцуудын туршлага судлах ажлуудыг хийхээр төлөвлөөд байна .

Үйл ажиллагааны 2-р хэсэг: ТБЦДС-ний үр ашгийн байдалд дүн шинжилгээ хийх хүрээнд зарим нэг агаарын шугаман дээр 1 жилийн хугацаатай хэмжилт хийж, компьютерийн тусгай программ ашиглаж хэмжилтийн үр дүнд шинжилгээ, судалгаа хийнэ. Энэ ажлын хүрээнд ЭХСХТ-д хэмжилтийн багаж нийлүүлэн сургалт, семинар зохион байгуулна. ТБЦДСүлжээнд хийсэн хэмжилт судалгааны ажлын жишээн дээр ЭХСХТ-өөс баруун бүсийн эрчим хүчний системийн үр ашгийн байдалд дүн шинжилгээ хийх ажлыг төлөвлөсөн.

Үйл ажиллагааны 3-р хэсэг: Энэ хэсэгт Монгол Улсын эрчим хүчний салбарын талаарх бодлогыг судалж, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн талаар бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, санал бэлтгэж өгөх, байгаль орчны бодлого боловсруулдаг байгууллагуудтай хамтран ажиллах, “Эрчим хүчний үр ашиг тооцох олон улсын

аргачлал” сэдэвт семинар зохион байгуулах зэрэг ажлууд хийхээр төлөвлөж байна.

Уг төслийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнгүүд гарна. Үүнд:

- ЭХСХТөвөөс Дулааны цахилгаан станц ба Цахилгаан шугам сүлжээний компаниудад зөвлөх үйлчилгээ сайжирч, мэргэжил дээшлүүлэх сургалтуудын хүрээ нэмэгдэнэ.
- ЭХСХТөв-ийн мэргэжилтнүүд Дулааны цахилгаан станцуудын ашиглалтын зарим нэг онцлог асуудлуудыг шийдвэрлэхэд мөн Цахилгаан шугам сүлжээний компаниудад алдагдал бууруулах чиглэлээр илүү сайн зөвлөгөө өгдөг болох.
- Дулааны цахилгаан станц ба Цахилгаан шугам сүлжээний компанийн инженерүүд үйлдвэрийнхээ үр ашгийг дээшлүүлэх нөөц, бололцоог илрүүлдэг болж, урт хугацаанд тогтвортой арга хэмжээнүүдийг авах талаар санал боловсруулдаг болох.
- Эрчим хүчний судалгааны байгууллага ба компаниуд нь эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх чадамжаа сайжруулах явдал юм.
- Эрчим хүчний үйлдвэрүүдийн үр ашиг дээшилж, санхүүгийн чадавхи сайжирна. Ингэснээр алдагдал нөхөхөд зориулан улсаас зарим нэг үйлдвэрт өгдөг төсвийн хөрөнгө багасна.
- Эрчим хүчний компаниудын зүгээс боловсон хүчнээ мэргэшүүлэх сонирхол өснө. Ингэснээр ажиллагсдын ажлын байр ба орлогын эх үүсвэр баталгаажихад тодорхой хувь нэмэр болох юм.
- ДЦС ба ЦШС-ний компаниудын эрчим хүчний үр ашиг дээшилснээр үйлдвэрийн АҮК дээшилнэ.
- Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд шаардлагатай нүүрсний хэрэглээ буурах ба ингэснээр станцаас хаягдах утаа ба агаар мандлын бохирдолтыг багасгахад хувь нэмрээ оруулна.⁶⁹

⁶⁹ ГТХАН-ийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын материал, Улаанбаатар, 2008.

Дүгнэлт

1991 оноос 2007 он хүртэлх хугацаанд ХБНГУ-ын Засгийн газраас Монгол Улсад нийт 253,49 сая орчим еврогийн хөгжлийн албан ёсны тусламжийг үзүүлснээс 120,29 сая орчим еврог техникийн тусламжид зарцуулсан байна.

Энэхүү хөрөнгө мөнгийг 2002 он хүртэл Монгол Улс, ХБНГУ-ын хоёр талын албан ёсны техникийн хамтын ажиллагааны хүрээнд эдийн засгийн шинэчлэлийг хөхүүлэн дэмжих, хувийн хэвшлийг хөгжүүлэх, экспортыг хөхүүлэн дэмжих, хүрээлэн буй орчныг хамгаалах, хөдөө орон нутгийг хөгжүүлэх, эрчим хүч, харилцаа холбоо, сургалт, давтан сургалт гэсэн үндсэн чиглэлтэйгээр мал аж ахуй, худалдаа, боловсруулах үйлдвэрийн салбар (мод боловсруулах, ноос боловсруулах), барилга, аялал жуулчлал, эрчим хүч, эрх зүй, банк санхүү, нийгэм, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчны салбарт тус тус зориулсан байдаг бол 2002 оноос хойш тогтвортой эдийн засгийн хөгжил, байгаль орчны бодлого (байгалийн нөөцийн хамгаалалт, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний нэгдэгдлийг бууруулах) гэсэн тэргүүлэх хоёр чиглэлд мал аж ахуй, худалдаа, боловсруулах үйлдвэрийн салбар (мод боловсруулах, ноос боловсруулах), барилга, аялал жуулчлал, эрчим хүч, эрх зүй, банк санхүү, эрүүл мэнд, байгаль орчны салбарт төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд зарсан байна.

Энэхүү өгүүлэлдээ ГТХАН-ийн Монгол Улсад хэрэгжүүлсэн яарим томоохон төслүүдийг түүвэрлэн төслийн хүрээнд хийгдсэн ажлуудыг ерөнхийлөн тоймлох замаар ямар төслийн хүрээнд ямар асуудлыг шийдэхийн тулд ямар ажлууд хийгдэв буюу энэ төсөл нь аль салбарын ямар асуудалд чиглэгдсэнийг харуулахыг оролдсон билээ. Цаашид ГТХАН-ийн эдгээр төслүүдийн үр дүнг бодитоор харахын тулд тэдгээр төсөл тус бүрийн хүрээнд шийдвэрлэхийг зорьсон тухайн тулгамдсан асуудал маань тэрхүү салбартаа хэр хэрэг чухал асуудал байв, ерөөсөө энэ салбар маань манай улсын хувьд тэргүүлэх салбар эсэх, төслийн хүрээнд хийгдсэн ажлууд нь тухайн салбарын цаашдын хөгжилд хэрхэн нөлөөлөв, төслийн хүрээнд шийдвэрлэхийг зорьсон тулгамдсан асуудлыг статистик үзүүлэлтээр илэрхийлж болох тохиолдолд төсөл хэрэгжсэн газруудын үг статистик үзүүлэлт нь төсөл хэрэгжээгүй бусад газруудаас ямар

ялгаатай байв, эсвэл төсөл хэрэгжихээс өмнөх үеийнхээс хэр зэрэг зөрүүтэй гарав гэх зэрэг асуудлыг нарийн судлах шаардлагатай бололтой. Нөгөө талаар ийнхүү судлахын ач холбогдол нь ГТХАН-ийн цаашдын төслүүдийг аль салбарын ямар тулгамдсан асуудалд эн тэргүүнд хандуулах нь чухал болохыг олж илрүүлэхэд орших билээ.